



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
САНДАГИЙН БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.08.24 № ЗГ-1/87
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Өгөгдлийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264003531



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026. 08. 20 № ХЭТ/2849
танай _____-ны № _____-т

「 Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тов
тогтоох тухай

Өгөгдлийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт²⁰⁰ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР


000265008496

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС



Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“8.ХЭЛЭЛЦСЭН нь: Өгөгдлийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Өгөгдлийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр

ӨГӨГДЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд дараах зорилт, арга хэмжээг 2021-2030 онд хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

а/“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.21-д “Их өгөгдөлд суурилсан, алгоритмын болон өндөр давтамжтай арилжааны платформыг нэвтрүүлэн хөрөнгийн зах зээл дэх технологийн дэвшлийг тогтмол хөгжүүлнэ.” гэж, 4.5.2-т “Инновац, технологи нэвтрүүлэх, мэдлэг хуваалцах чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.” гэж, 4.6.10-т “Мэдлэгийн эдийн засгийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.” гэж;

б/мөн уг арга хэмжээний 5.3.1-д “Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.” гэж, 5.3.5-д “Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно.” гэж, 5.5.1-д “Хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж, хөгжүүлнэ.” гэж;

в/түүнчлэн уг арга хэмжээний 6.4.4-т “Бохирдол, хаягдлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, цэвэр үйлдвэрлэл, хэмнэлттэй хэрэглээг эдийн засгийн хөшүүргээр дэмжинэ.” гэж, 7.5.8-д “Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, уян болон хатуу дэд бүтцийг хөгжүүлнэ.” гэж, 7.5.26-д “Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож, хөгжүүлнэ.” гэж, 9.5.17-д “Газар зүйн байршлын давуу талаа ашиглан олон улсын “Мэдээллийн дата төв”-ийг байгуулна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн”-ийн 10.2-т “Өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар дижитал эдийн засгийг нэмэгдүүлнэ.” гэж, 10.2.1.1-д “Олон улсын дата төвийн чөлөөт бүс бий болгох замаар мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.3.2.4-т “Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, үүлэн тооцоолуур, блокчейн, юмсын интернэтийг төрийн үйл ажиллагаа, үйлчилгээнд хэрэглэж болох чиглэлүүдийг тодорхойлж, судалгааны

ажлуудыг санхүүжүүлж, үе шаттай туршилтын төслүүдийг эхлүүлнэ. Төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжинэ.” гэж, 4.3.3.1-д “Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого, зохистой хэрэглээний талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж тодорхойлсон.

Энэхүү бодлогын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааны явцад бүрдүүлэн ашиглаж байгаа өгөгдөл, мэдээллийг нэгтгэн, нөхцөл байдлыг дүгнэх, үнэлгээний үр дүнд их өгөгдөл бий болгоход шаардлагатай арга, хэрэгслийг тодорхойлох зорилгоор “Их өгөгдлийн сан” үүсгэх шийдвэрийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 403 дугаар тогтоолоор баталсан.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлээр “өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин ашиглах талаар эрх зүйн орчныг бүрдүүлэх, Монгол Улсад эрчим хүчний хэмнэлттэй “Ногоон дата төв” байгуулах бэлтгэл ажлыг хангах талаар” үүрэг болгосны дагуу төрийн цахим мэдээллийн нэгдсэн санг зөвхөн өгөгдөл цуглуулах, хадгалах зориулалтаар бус, харин эдийн засаг, инновац, эрдэм шинжилгээ, төрийн үйлчилгээ болон хувийн хэвшлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд аюулгүй, чанартай, үр ашигтайгаар ашиглуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүсэж байна.

1.2.Практик шаардлага

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасны дагуу хууль санаачлагчаас “Өгөгдлийн тухай хууль”-ийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах судалгаа хийж, өгөгдлийн харилцаатай холбоотой эрх зүйн байдлын өнөөгийн бодит нөхцөл байдал, үүссэн хүндрэл, түүнийг бие даасан хуулиар зохицуулах хэрэгцээ шаардлагыг судалсан болно.

Дэлхийн хэмжээнд өгөгдлийн хурдацтай өсөлт болон технологийн дэвшил нь өгөгдлийн төвүүдийн дэд бүтцийг өргөжүүлэх, их өгөгдлийн зах зээлийг эрчимтэй хөгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж байна. Тодруулбал, өгөгдлийн урсгалын хэмжээ 2024 онд 149 зеттабайт байсан бол 2028 онд 394 зеттабайт болж өсөх төлөвтэй байгаа нь өгөгдөл хадгалах, боловсруулах эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, одоогоор үйл ажиллагаа явуулж буй 11,000 гаруй өгөгдлийн төвийг улам өргөжүүлэхэд хүргэж байна. Энэхүү өсөлтөд хиймэл оюуны хөгжил чухал нөлөө үзүүлж байгаа бөгөөд ирэх 5-10 жилийн хугацаанд үүлэн технологид суурилсан өгөгдлийн төвүүдийн хүчин чадлыг 200 гигаваттаас давуулахад түлхэц болно.

Дэлхийн их өгөгдлийн зах зээл 2023 онд 327.26 тэрбум ам.доллараар үнэлэгдсэн ба 2024-2030 оны хооронд жилд дунджаар 14.9 хувиар өсөхөөр тооцоолол гарсан нь өгөгдлийн хэрэглээ, хиймэл оюуны дэвшил, зах зээлийн тэлэлт хоорондоо нягт уялдаатайгаар өгөгдлийн дэд бүтцийн хөгжлийг шинэ шатанд гаргаж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2021 онд цахим хөгжлийг дэмжих багц хуулиудыг баталсан нь өгөгдөлтэй холбоотой харилцааг зохицуулах суурь эрх зүйн орчныг бүрдүүлсэн чухал алхам болсон. Эдгээр хуулиар нийтийн мэдээллийн ил тод байдал, хүний хувийн мэдээлэл хамгаалах, кибер аюулгүй байдал, цахим гарын үсэг, цахим үйлчилгээний суурь зарчим, шаардлагыг тодорхой хэмжээнд зохицуулсан боловч практик хэрэгжилтийн түвшинд өгөгдлийг байгууллага, салбар, мэдээллийн систем хооронд солилцох, нэгтгэх, чанаржуулах, дахин ашиглах, өгөгдлийн бүтээгдэхүүн болгох, эдийн засгийн эргэлтэд оруулах, өгөгдлийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт татах харилцааг бүрэн хамарч чадаагүй байна.

Мөн өгөгдлийн ангилал, өмчлөл, эзэмшил болон ашиглах эрхийг нэгдсэн байдлаар хуульчлан тодорхойлоогүй, төр, хувийн хэвшил, иргэн хооронд өгөгдөл солилцох, хамтран ашиглах, дахин ашиглах, арилжаалах, зуучлах эрх зүйн зохицуулалт бүрдээгүй, инновац, хиймэл оюуныг хөгжүүлэхэд шаардлагатай их өгөгдөл хангалтгүй, өгөгдлийг анхны зорилгоос өөрөөр дахин ашиглах нөхцөлийг зохицуулаагүйгээс өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжгүй байна.

Өгөгдлийн бодлого, зохицуулалтын хүрээнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас 2026 онд төрийн болон хувийн хэвшлийн 75 байгууллагаас судалгаа авч, дүн шинжилгээ хийсэн. Уг судалгаагаар өгөгдөл солилцох, хуваалцах, ашиглах, дахин ашиглах зохицуулалт дутмаг, төрийн байгууллагууд ижил төрлийн мэдээллийг давхардуулан цуглуулдаг, өгөгдлийг шинэчлэх давтамж зөрүүтэй, өгөгдлийн чанар, стандартыг баталгаажуулах тогтолцоо байхгүй, өгөгдөл солилцооны дэд бүтцийн харилцан уялдаа сул, өгөгдлийн аюулгүй байдал хангагдсан эсэх талаарх иргэн, байгууллагын итгэл сул гэсэн дүгнэлт гарсан.

Түүнчлэн, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, тэдгээрийн эрэлт, хэрэгцээг харгалзан эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй, хязгаарлалттай болон хаалттай мэдээллийн хүн, хуулийн этгээд, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нээлттэй өгөгдөл болгож ашиглах талаар зохицуулсан хэдий ч хаалттай, хязгаарлалттай мэдээллийг тодорхой нөхцөл, эрх, зөвшөөрлийн хүрээнд дахин ашиглах эрх зүйн зохицуулалтгүй байна.

Энэ нь төр, хувийн хэвшил, судалгаа шинжилгээний байгууллагуудын хооронд өгөгдөлд суурилсан хамтын ажиллагаа хөгжихгүй, өгөгдлийг давхардуулан үүсгэх, цуглуулах, инновац болон өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, хиймэл оюуны хөгжүүлэлт удаашрах, төрийн үйлчилгээний үр ашиг буурах зэрэг хүндрэл үүсэж байна.

Олон улсын түвшинд OECD¹ өгөгдлийг орчин үеийн эдийн засаг, инновац, төрийн удирдлага, судалгаа хөгжүүлэлт, санхүү зэрэг олон салбарт үнэ цэн бий болгох “стратегийн нөөц” гэж үзэж, өгөгдлийн засаглалыг өгөгдөл үүсэхээс устах хүртэл өгөгдлийн амьдралын мөчлөгийн дагуу удирдах шаардлагатайг онцолж байна. Тухайлбал, өгөгдөлд хандах, өгөгдөл хуваалцах, дахин ашиглах бодлого нь өгөгдлийн нийгэм, эдийн засгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хувийн нууц, оюуны өмч, өрсөлдөөн, байгууллага болон хувь хүний эрх ашиг, итгэлцлийн эрсдэл зэргийг харгалздаг.

Өгөгдлийг хаалттай байдлаар хамгаалах нь өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжилд сөргөөр нөлөөлөх, харин чөлөөтэй урсгалд оруулбал хүний эрх, хувийн мэдээлэл, бизнесийн нууц, кибер аюулгүй байдал, шударга өрсөлдөөнд эрсдэл учруулна гэж үзэж, энэ тэнцвэрийг хангахын тулд “итгэлцэлд суурилсан өгөгдлийн чөлөөт урсгал” (Data free flow with Trust-DFFT) зарчмыг² улс орнуудад санал болгож байна.

Өгөгдлийн дэд бүтэц, өгөгдлийн засаглал болон өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн зохицуулалт нь орчин үед зөвхөн өгөгдлийг хамгаалах хүрээнд хязгаарлагдахгүйгээр, өгөгдлийн амьдралын мөчлөгийн бүх үе шат болох өгөгдөл үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, хадгалах, хандах, дамжуулах, солилцох, ашиглах, дахин ашиглах, архивлах, устгах үйл явцыг хамруулан цогц байдлаар хөгжүүлж байна.

Үүнтэй уялдан улс орнууд өгөгдлийн дэд бүтэц, үүлэн тооцоолуур, өгөгдлийн стандарт, аюулгүй байдал, хил дамнасан өгөгдлийн урсгал, хиймэл оюуны сургалтын өгөгдөл, өгөгдлийн өмчлөл, хандалтын эрх, өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх зохицуулалтыг үе шаттайгаар бүрдүүлж байна. Тухайлбал,

- Бүгд Найрамдах Казакстан Улс 2026 онд баталсан “Цахим кодекс”-оор дижитал өгөгдөл, дижитал объект, дижитал орчны харилцааг нэгдсэн байдлаар зохицуулах эрх зүйн суурь бүрдүүлсэн бөгөөд уг кодексын зорилтод дижитал орчны харилцааг эрх зүйн зохицуулалтаар хангах, дижитал салбарт хөрөнгө оруулалт татах нөхцөл бүрдүүлэх,

¹ <https://www.oecd.org/en/topics/sub-issues/data-governance>

² Data Free Flow with Trust, DFFT/ нь дижитал технологийн улмаас үүсэж, цугларч, хуулбарлагдаж, ашиглагдаж буй их хэмжээний өгөгдөл улсын хил дамнаш шилжих болсон нөхцөлд өгөгдлийн чөлөөт урсгалыг дэмжихийн зэрэгцээ хувийн нууц, аюулгүй байдал, оюуны өмчийн эрхийн хамгаалалтад итгэлцэл бий болгох зорилготой олон улсын бодлогын зарчим юм.

дигитал өгөгдлийн эргэлтийн эрх чөлөө болон хүний эрх, аюулгүй байдлын зарчмыг хамтад нь тусгаж, ногоон хөгжил, тогтвортой өсөлтийн замын зураг гаргасан³.

- Япон Улсын хувьд өндөр хурдны мэдээлэл боловсруулах зориулалттай хагас дамжуулагч, мэдээлэл боловсруулах тоног төхөөрөмж, байгууламжийг стратегийн дэд бүтэц гэж үзэж, өндөр хурдны мэдээлэл боловсруулах тоног төхөөрөмж нэвтрүүлэхэд шаардлагатай хөрөнгийн зээл, бондод баталгаа гаргах, тоног төхөөрөмж болон байгууламжид хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх, хиймэл оюун ухаан болон хагас дамжуулагчийн аж үйлдвэрийн суурийг бэхжүүлэх бодлогын арга хэмжээг хууль, санхүүгийн механизмаар дэмжиж байна.⁴

- Сингапур Улс дата төвийг дигитал эдийн засгийн суурь дэд бүтэц гэж үзэж, дигитал эдийн засгийг хөгжүүлэх зорилтыг дэмжих үүднээс дата төвүүдийн цаашдын өсөлтийг тогтвортой хэлбэрээр хангах бодлогын чиглэлийг "Green Data Centre Roadmap"-аар тодорхойлсон байна.⁵

Монгол Улс газар зүйн байршлын давуу талдаа түшиглэсэн олон улсын дата төв байгуулж, их өгөгдөлд суурилсан нэгдсэн сан болон төрийн цахим ой санамжийн аюулгүй байдал, нэг эх сурвалж бүхий өгөгдлийг бий болгох замаар судалгаа шинжилгээ, инновацын уян болон хатуу дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэх шаардлагатай байна.

Иймд өгөгдөл, мэдээллийг хуваалцах, ашиглах, дахин ашиглах эрх зүйн үндсийг тогтоож, өгөгдлийн аюулгүй байдал, чанар, хүртээмжийг хангах, өгөгдөлд суурилсан инновац, үйлдвэрлэлийг дэмжих асуудлыг цогцоор нь шийдвэрлэсэн Өгөгдлийн тухай хуулийн төслийг боловсруулах практик шаардлага үүсээд байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь өгөгдлийн дэд бүтэц, эрх зүйн үндэс болон өгөгдлийн засаглалыг бүрдүүлж, өгөгдлийн чанар, аюулгүй байдал, хүртээмж, халдашгүй байдлыг хангах замаар өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулах бөгөөд дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

1/нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, өгөгдлийн тухай хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, өгөгдлийн харилцаанд баримтлах зарчмын тухай;

2/өгөгдлийн дэд бүтцийг тодорхойлж, төрийн их өгөгдөл, өгөгдлийн санг мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, кодын дагуу үүсгэх, сангаас ашиглах зориулалтаас нь шалтгаалж өгөгдлийг ангилж, хүртээмжтэй ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг;

3/өгөгдлийн амьдралын мөчлөг буюу өгөгдөл үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, ашиглах, солилцох, дамжуулах, хадгалах, нөөцлөх, устгахтай холбоотой зохицуулалтыг;

4/өгөгдлийг туршилтын орчинд ашиглах зохицуулалтыг бий болгох, Монгол Улсад дотоодын болон гадаадын дата төв (ногоон дата төв), үндэстэн дамнасан олон улсын дата төвийн үйл ажиллагааг эрхлэх, уг үйл ажиллагааг Монгол Улсын чөлөөт бүсэд эрхлэхтэй холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, тэдгээрт хадгалж буй өгөгдлийн халдашгүй байдлыг хангахтай холбоотой тусгай дэглэм бүхий харилцааг;

5/өгөгдлийн харилцаанд оролцогч, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүргийг тодорхойлж, өгөгдлийн засаглалын тогтолцоог бэхжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг;

³ Digital code of The Republic of Kazakhstan <https://cislegislation.com>

⁴ Act for Partially Amending the Act on Facilitation of information Processing and the Act on Special Accounts <https://www.meti.go.jp/english/press/2025/0207>

⁵ About <https://www.imda.gov.sg>

6/өгөгдлийн чанар, аюулгүй байдлыг хангах замаар өгөгдлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, өгөгдөл солилцох үйл ажиллагаанд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэх, өгөгдлийн харилцаанд хориглох зохицуулалт, өгөгдлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар өгөгдлийн амьдралын мөчлөгийг зохицуулах, өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулахад төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааны эрх зүйн орчин боловсронгуй болж, нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараах эерэг үр дагавар үүснэ. Үүнд:

1.Төр, хувийн хэвшил, иргэн хооронд өгөгдлийг хуульд нийцүүлэн, аюулгүй солилцох, дахин ашиглах нөхцөл бүрдэж, өгөгдлийн ангилал, эзэмшил, ашиглалтын эрх, оролцогч талуудын хариуцлага тодорхойлогдон, өгөгдлийн засаглал сайжирч, өгөгдөл, мэдээллийг давхардуулан цуглуулах болон мэдээллийн зөрүү буурч, төрийн үйлчилгээний уялдаа холбоо, үр ашиг нэмэгдэнэ. Мөн өгөгдлийн аюулгүй байдал, нууцлал, хяналт, аудитын тогтолцоо боловсронгуй болж, иргэн, хуулийн этгээдийн итгэл нэмэгдэхээс гадна олон улсын жишигт нийцсэн зохицуулалт бүрдсэнээр хил дамнасан өгөгдөл ашиглалт, дижитал хамтын ажиллагааны эрх зүйн орчин бэхэжнэ.

2.Монгол Улсад өгөгдлийг зөвхөн төрийн мэдээллийн сан, байгууллагын дотоод мэдээлэл, эсхүл техникийн нөөц хэлбэрээр бус, хууль ёсны, аюулгүй, гэрээ, лицензийн тодорхой нөхцөлөөр ашиглуулснаар эдийн засгийн үнэ цэн бүхий өгөгдөл, өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болж, өгөгдлийн худалдаа, зуучлал, үнэлгээний шинэ зах зээл үүсэж, мэдээллийн технологийн салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ өснө.

3.Өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, судалгаа, инновац, хиймэл оюуны шийдэл хөгжүүлэх боломж нэмэгдэх ба дата төв, үүлэн тооцоолуурын үйлчилгээ, хиймэл оюуны тооцоолох хүчин чадал бүхий нөөц төв, суурь дэд бүтцэд дотоод, гадаадын хөрөнгө оруулалт татах эрх зүйн орчин бүрдэнэ.

4.Өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт бий болсноор төрийн бодлого оновчтой, үр ашигтай болж, төсвийн хөрөнгийн хуваарилалтыг илүү үр дүнтэй зарцуулах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ чанартай, хүртээмжтэй өгөгдөл нь шийдвэр гаргалтын өртөг, зардлыг бууруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.

5.Аж ахуйн нэгжүүд өгөгдөлд суурилсан оновчтой шийдвэр гаргалт хийдэг болсноор логистик, үйлдвэрлэл, маркетинг, хүний нөөцийн зэрэг үргүй зардал эрс багасна.

6.Монгол Улсад хамаарахгүй өгөгдлийн халдашгүй байдал (data sovereignty)-ыг үндэсний аюулгүй байдал, кибер хамгаалалт, мэдээллийн тусгаар тогтнолын хүрээнд хуульчлан баталгаажуулж, стратегийн өгөгдлийг хамгаалах тусгай дэглэм тогтоосноор олон улсын дата төвүүд байгуулагдан Төв Ази, Зүүн хойд Азийн бүсийн өгөгдлийг хадгалах, дамжуулах "Дата тээвэр ба хадгалалт"-ын үйлчилгээний экспортын шинэ орлого үүснэ.

7.Эдийн засгийн чөлөөт бүсийн хүрээнд байгуулагдах дата төв, үүлэн тооцоолуур, хиймэл оюуны цогцолборыг стратегийн дэд бүтэц гэж үзэж тэдгээрийг урт хугацааны хямд, найдвартай эрчим хүчний хангамж, сэргээгдэх эх үүсвэрт суурилсан ногоон санхүүжилт болон тарифын тусгай зохицуулалтаар төрөөс дэмжих эрх зүйн зохицуулалт бий болно.

8.Дата төвийн өгөгдлийг хадгалах, боловсруулах, дамжуулах бүх үе шатанд нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангахын зэрэгцээ дата урсгалын багтаамжийг нэмэгдүүлж, шилэн кабель болон хиймэл дагуулд суурилсан гибрид

сүлжээг хөгжүүлэн өгөгдлийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай, аюулгүй байдлыг хуулиар хамгаална.

Дөрөв.Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, өмчийн эрхийг хамгаалах, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэх эрх чөлөөг баталгаажуулах, үндэсний аюулгүй байдлыг хангах суурь зарчимд нийцүүлэн боловсруулагдана. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн хүний эрх, хувийн мэдээлэл, хувийн нууц, мэдээлэл хайх, хүлээн авах эрх, шинжлэх ухаан, технологи, цахим худалдаа, кибер аюулгүй байдал, хөрөнгө оруулалттай холбоотой нийтлэг зарчимд харшлахгүй. Зохицуулалтын арга барил нь хүний эрх болон эрсдэлд суурилсан, ил тод, ялгаварлалгүй, хариуцлагатай, кибер аюулгүй байдлыг хангасан байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

-----o0o-----

ӨГӨГДЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.Хуулийн төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтын талаар

Хуулийн төслөөр өгөгдөл үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, ашиглах, солилцох, дамжуулах, хадгалах, нөөцлөх, устгахтай холбоотой харилцааг зохицуулах, өгөгдлийн засаглалын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, өгөгдлийн чанар, аюулгүй байдал, хүртээмж, халдашгүй байдлыг хангах харилцааг зохицуулж, дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг бүрдүүлэх нөхцөлийг тогтоосон.

Хуулийн төсөлд өгөгдлийн харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, өгөгдлийн чанар, аюулгүй байдал, хүртээмж, харилцан ажиллагаа, нууцлал, халдашгүй байдлыг хангах суурь зарчмуудыг тусгасан. Мөн өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, инновацыг хөгжүүлэх, Монгол Улсыг бүс нутгийн дата төв болгон хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг тусгасан болно.

Хуулийн төслийн онцлог нь өгөгдлийн амьдралын мөчлөг (өгөгдөл үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, ашиглах, солилцох, дамжуулах, хадгалах, нөөцлөх, устгах)-ийг бүхэлд нь хамарсан зохицуулалтыг анх удаа хуульчлан тогтоож байгаад оршино. Түүнчлэн өгөгдлийн сангийн нэгдсэн ангилал, код, өгөгдлийн чанарын удирдлага, өгөгдөл солилцооны нэгдсэн тогтолцоо, өгөгдлийн дэд бүтэц, дата төвийн үйл ажиллагаа, өгөгдлийн туршилтын орчин (сэндбокс)-ыг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаа нь өгөгдлийн засаглалын цогц тогтолцоог бий болгоход чиглэж байна.

Өгөгдлийн засаглалын тогтолцоог бүрдүүлэх хүрээнд өгөгдлийн харилцаанд оролцогчийг тодорхойлж, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлох, төрийн байгууллагуудын өгөгдөл солилцооны нэгдсэн архитектур, стандартыг тогтоох, өгөгдлийн чанарын удирдлагыг хэрэгжүүлэх, өгөгдлийн нэгдсэн бүртгэл, каталогийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулсан бөгөөд дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

1/нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, өгөгдлийн тухай хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, нэр томьёоны тодорхойлолт, өгөгдлийн харилцаанд баримтлах зарчмын тухай;

2/өгөгдлийн дэд бүтцийг тодорхойлж, төрийн их өгөгдөл, өгөгдлийн санг мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, кодын дагуу үүсгэх, сангаас ашиглах зориулалтаас нь шалтгаалж өгөгдлийг ангилж, хүртээмжтэй ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг;

3/өгөгдлийн амьдралын мөчлөг буюу өгөгдөл үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, ашиглах, солилцох, дамжуулах, хадгалах, нөөцлөх, устгахтай холбоотой зохицуулалтыг;

4/өгөгдлийг туршилтын орчинд ашиглах зохицуулалтыг бий болгох, Монгол Улсад дотоодын болон гадаадын дата төв (ногоон дата төв), үндэстэн дамнасан олон улсын дата төвийн үйл ажиллагааг эрхлэх, уг үйл ажиллагааг Монгол Улсын чөлөөт бүсэд эрхлэхтэй холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, тэдгээрт хадгалж буй өгөгдлийн халдашгүй байдлыг хангахтай холбоотой тусгай дэглэм бүхий харилцааг;

5/өгөгдлийн харилцаанд оролцогч, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүргийг тодорхойлж, өгөгдлийн засаглалын тогтолцоог бэхжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг;

6/өгөгдлийн чанар, аюулгүй байдлыг хангах замаар өгөгдлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, өгөгдөл солилцох үйл ажиллагаанд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэх, өгөгдлийн харилцаанд хориглох зохицуулалт, өгөгдлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар.

2.Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал

Монгол Улсын Их Хурлаас 2021 онд цахим хөгжлийг дэмжих багц хуулиудыг баталсан нь өгөгдлийн талаарх суурь эрх зүйн орчныг бүрдүүлсэн чухал алхам болсон бөгөөд өгөгдөл үүсгэх, цуглуулах, боловсруулах, ашиглах, солилцох болон түүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцааг салбарын дараах хуулиудаар хэсэгчлэн зохицуулж ирсэн. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хуулиар: Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууцыг хамгаалах буюу иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар: Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах үндсэн зарчим болон мэдээлэл цуглуулах, ашиглах үндэслэл, мэдээллийн эзэн, мэдээлэл хариуцагчийн эрх, үүргийг;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар: Нийтийн мэдээллийн ангилал, мэдээлэл хариуцагчийн хүлээх үүрэг, нийтийн мэдээллийн дэд бүтэц ашиглан өгөгдлийг давхардалгүйгээр үүсгэх, цуглуулах, боловсруулах, солилцох, хамгаалах болон нээлттэй өгөгдөл бий болгох харилцааг;
- Кибер аюулгүй байдлын тухай болон Цахим гарын үсгийн тухай хуулиар: Цахим орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан байдал, мэдээлэл солилцооны аюулгүй байдал, цахим итгэлцлийг бий болгох асуудлыг;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуулиар: Хаалттай мэдээллийн ангилал, түүнийг хамгаалах, ашиглах тусгай зохицуулалтыг;
- Статистикийн тухай хуулиар: Албан ёсны статистикийн мэдээлэл, өгөгдлийг цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг;

- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулиар: Төрийн мэдээллийг урт хугацаанд хадгалах, архивлах, дахин ашиглах журмыг тус тус зохицуулж байна.

Гэвч дээрх хуулиуд нь өгөгдөл, мэдээллийг хамгаалах, ил тод болгох, эсхүл салбарын хэрэгцээнд ашиглахад чиглэсэн зохицуулалтууд бөгөөд өгөгдлийг анхны зорилгоос нь өөрөөр ашиглах буюу дахин ашиглах (data re-use) эрх зүйн зохицуулалт бүрдээгүйгээс гадна практик хэрэгжилтийн түвшинд өгөгдлийг байгууллага, салбар, мэдээллийн систем хооронд солилцох, нэгтгэх, чанаржуулах, дахин ашиглах, өгөгдлийн бүтээгдэхүүн болгох, эдийн засгийн эргэлтэд оруулах, өгөгдлийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт татах харилцааг бүрэн хамарч чадаагүй байна. Тухайлбал:

1. Өгөгдөл, мэдээллийн өмчлөл, ашиглалтын эрх тодорхойгүй буюу өгөгдлийн ангилал, өмчлөл, эзэмшил болон ашиглах эрхийг нэгдсэн байдлаар хуульчлан тодорхойлоогүй;
2. Өгөгдөл, мэдээллийг хуваалцах, дахин ашиглах, арилжаалах, зуучлахтай холбоотой зах зээлийн харилцаа зохицуулагдаагүй;
3. Төр, хувийн хэвшил, иргэн хооронд хооронд өгөгдөл солилцох, хамтран ашиглах, өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн зохицуулалт дутмаг;
4. Өгөгдлийн засаглал, хариуцлагын тогтолцоо, стандарт, мэдээллийн системүүдийн харилцан ажиллагааны нэгдсэн архитектур хангалтгүй;
5. Инновац, хиймэл оюуныг хөгжүүлэхэд шаардлагатай их өгөгдөл (Big Data) болон боловсруулсан өгөгдөл хангалтгүй байна.

Иймд өгөгдөл, мэдээллийг хуваалцах, ашиглах, дахин ашиглах эрх зүйн үндсийг тогтоож, өгөгдлийн аюулгүй байдал, чанар, хүртээмжийг хангах, өгөгдөлд суурилсан инноваци, үйлдвэрлэлийг дэмжих асуудлыг цогцоор нь шийдвэрлэсэн Өгөгдлийн тухай хуулийн төслийг боловсруулах практик шаардлага үүсээд байна.

3.Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Хуулийн төсөл боловсруулах хүрээнд төрийн байгууллага, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын төлөөлөлтийг оролцуулан Өгөгдлийн тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2026 оны А/63 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлээр “өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин ашиглах талаар эрх зүйн орчныг бүрдүүлэх, Монгол Улсад эрчим хүчний хэмнэлттэй “Ногоон дата төв” байгуулах бэлтгэл ажлыг хангах талаар” үүрэг болгосны дагуу төрийн цахим мэдээллийн нэгдсэн санг зөвхөн өгөгдөл цуглуулах, хадгалах зориулалтаар бус, харин эдийн засаг, инновац, эрдэм шинжилгээ, төрийн үйлчилгээ болон хувийн хэвшлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд аюулгүй, чанартай, үр ашигтайгаар ашиглуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасны дагуу

Өгөгдлийн тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаа хийж, өгөгдлийн харилцаатай холбоотой эрх зүйн байдлын өнөөгийн бодит нөхцөл байдал, үүссэн хүндрэл, түүнийг бие даасан хуулиар зохицуулах хэрэгцээ шаардлага болон хүний эрх, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөө, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийсэн.

Мөн Европын Холбоо, Бүгд Найрамдах Эстони Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Сингапур Улсын өгөгдлийн засаглал, өгөгдлийн ангилал, хил дамнасан өгөгдлийн бодлого, институцийн тогтолцооны харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэсэн.

Дэлхийн хэмжээнд өгөгдлийн хурдацтай өсөлт болон технологийн дэвшил нь өгөгдлийн төвүүдийн дэд бүтцийг өргөжүүлэх, их өгөгдлийн зах зээлийг эрчимтэй хөгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж байна. Тодруулбал, өгөгдлийн урсгалын хэмжээ 2024 онд 149 зеттабайт байсан бол 2028 онд 394 зеттабайт болж өсөх төлөвтэй байгаа нь өгөгдөл хадгалах, боловсруулах эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, одоогоор үйл ажиллагаа явуулж буй 11,000 гаруй өгөгдлийн төвийг улам өргөжүүлэхэд хүргэж байна. Энэхүү өсөлтөд хиймэл оюуны хөгжил чухал нөлөө үзүүлж байгаа бөгөөд ирэх 5-10 жилийн хугацаанд үүлэн технологид суурилсан өгөгдлийн төвүүдийн хүчин чадлыг 200 гигаваттаас давуулахад түлхэц болно.

Дэлхийн их өгөгдлийн зах зээл 2023 онд 327.26 тэрбум ам.доллараар үнэлэгдсэн ба 2024-2030 оны хооронд жилд дунджаар 14.9 хувиар өсөхөөр тооцоолол гарсан нь өгөгдлийн хэрэглээ, хиймэл оюуны дэвшил, зах зээлийн тэлэлт хоорондоо нягт уялдаатайгаар өгөгдлийн дэд бүтцийн хөгжлийг шинэ шатанд гаргаж байна.

Өгөгдлийн бодлого, зохицуулалтын хүрээнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилгоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас 2026 онд төрийн болон хувийн хэвшлийн 75 байгууллагаас судалгаа авч, дүн шинжилгээ хийсэн. Уг судалгаагаар өгөгдөл солилцох, хуваалцах, ашиглах, дахин ашиглах зохицуулалт дутмаг, төрийн байгууллагууд ижил төрлийн мэдээллийг давхардуулан цуглуулдаг, өгөгдлийг шинэчлэх давтамж зөрүүтэй, өгөгдлийн чанар, стандартыг баталгаажуулах тогтолцоо байхгүй, өгөгдөл солилцооны дэд бүтцийн харилцан уялдаа сул, өгөгдлийн аюулгүй байдал хангагдсан эсэх талаарх иргэн, байгууллагын итгэл сул гэсэн дүгнэлт гарсан.

Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, тэдгээрийн эрэлт, хэрэгцээг харгалзан эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй, хязгаарлалттай болон хаалттай мэдээллийн хүн, хуулийн этгээд, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нээлттэй өгөгдөл болгож ашиглах талаар зохицуулсан хэдий ч хаалттай, хязгаарлалттай мэдээллийг тодорхой нөхцөл, эрх, зөвшөөрлийн хүрээнд дахин ашиглах эрх зүйн зохицуулалтгүй байна. Энэ нь төр, хувийн хэвшил, судалгаа шинжилгээний байгууллагуудын хооронд өгөгдөлд

суурилсан хамтын ажиллагаа хөгжихгүй, өгөгдлийг давхардуулан үүсгэх, цуглуулах, инновац болон өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, хиймэл оюуны хөгжүүлэлт удаашрах, төрийн үйлчилгээний үр ашиг буурах зэрэг хүндрэл үүсгэж байна.

Олон улсын байгууллагуудаас өгөгдлийг орчин үеийн эдийн засаг, инновац, төрийн удирдлага, судалгаа хөгжүүлэлт, санхүү зэрэг олон салбарт үнэ цэн бий болгох “стратегийн нөөц” гэж үзэж, өгөгдлийн засаглалыг өгөгдөл үүсэхээс устгах хүртэл өгөгдлийн амьдралын мөчлөгийн дагуу удирдах шаардлагатайг онцолж байна.

4.Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн

Хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2026 оны 6 дугаар сарын 09-23-ны хооронд яам, агенлаг, хороодууд, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчид, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид, дата төвийн үйл ажиллагаа эрхлэгчид, финтекийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, арилжааны банкууд, шинжлэх ухааны академи, их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулахаар төлөвлөсөн.

5.Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт

Тандан судалгааны хүрээнд Европын Холбооны улс, Бүгд Найрамдах Эстони улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Сингапур зэрэг улсуудын өгөгдлийн засаглалын өнөөгийн нөхцөл байдал, SWOT шинжилгээ болон өгөгдлийн бодлогод туссан үр дүн, үзүүлэлтийг жишээ болгон судалсан.

Европын Холбоо, Эстони, БНСУ, Сингапур улсуудын туршлагаас харахад өгөгдлийг үндэсний хөгжлийн стратегийн нөөц гэж үзэж, түүнийг удирдах институцийн тогтолцоо, өгөгдлийн дэд бүтэц, өгөгдөл солилцооны платформ, хүний нөөцийн чадавх, иргэдийн итгэлцлийг цогцоор нь бүрдүүлсэн эсэхээс шууд хамаарч байна. Судалгаанд хамрагдсан улс орнуудын нийтлэг шинж нь өгөгдлийг хамгаалах болон өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах гэсэн хоёр зорилтыг зэрэг хангах бодлого хэрэгжүүлж байгаа явдал юм. Европын Холбооны GDPR, Өгөгдлийн засаглалын тухай хууль, Өгөгдлийн хууль зэрэг эрх зүйн зохицуулалтаар иргэдийн эрхийг хамгаалахыг нэн тэргүүнд тавьсан бол БНСУ, Сингапур нь инновац болон өгөгдлийн ашиглалтыг дэмжих уян хатан зохицуулалтыг түлхүү хөгжүүлсэн байна. Харин Эстони улс өгөгдлийг төрийн үйлчилгээний үндсэн дэд бүтэц болгон ашиглаж, төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдмэл солилцооны тогтолцоог бүрдүүлсэн нь онцлог байна.

Дээрх улс орнуудын туршлагаас харахад дараах хүчин зүйлсийн нөлөөгөөр өгөгдлийн засаглалыг амжилттай хөгжүүлж байна:

1.Өгөгдлийн бодлого, зохицуулалтын байгууллага-Өгөгдлийн бодлого, стандарт, хамгаалалт, хяналтыг нэгдсэн байдлаар удирдан чиглүүлдэг бие даасан байгууллагатай байна.

2.Өгөгдөл солилцооны үндэсний платформ, архитектур-Эстонийн X-Road, БНСУ-ын нэгдсэн платформ, Сингапур улсын Засгийн газрын нэгдсэн өгөгдлийн

архитектур зэрэг нь төрийн өгөгдлийн давхардлыг бууруулж, өгөгдлийн ашиглалтыг нэмэгдүүлж байна.

3.Өгөгдлийн ангилал, хамгаалалтын шаталсан тогтолцоо-Нээлттэй, хязгаарлагдмал, хаалттай, эмзэг мэдээллийг ялган зохицуулснаар өгөгдлийн ил тод болон аюулгүй байдлын тэнцвэр хангагдаж байна.

4.Хил дамнасан өгөгдлийн урсгалыг дэмжих бодлого-Өгөгдлийг дотооддоо хадгалах хатуу шаардлагаас илүү хамгаалалтын үр дүнд суурилсан хандлагыг түлхүү ашиглаж байна.

5.Өгөгдлийн соёл ба хүний нөөцийн хөгжил-Төрийн албан хаагч, иргэд, хувийн хэвшлийн байгууллагуудын өгөгдлийн талаарх мэдлэг, мэдээллийг тасралтгүй хөгжүүлж байна.

SWOT шинжилгээний үр дүнг нэгтгэн үзвэл дээрх улс орнуудын гол давуу тал нь өгөгдлийн талаарх эрх зүйн орчин бүрдсэн, төрийн манлайлал сайн, харилцаа холбооны дэд бүтэц хөгжсөн, өгөгдөлд суурилан шийдвэр гаргалт сайжирсан байгаа бол нь кибер аюулгүй байдал, хувийн мэдээллийн хамгаалалт, өгөгдлийн чанар, олон байгууллагын уялдаа холбоог хангах асуудал нийтлэг сорилт болж байна. Харин хиймэл оюун, өгөгдлийн эдийн засгийн өсөлт, хил дамнасан өгөгдлийн урсгал нь томоохон боломжийг бий болгож байгаа хэдий ч геополитик, кибер аюул, технологийн хараат байдал нь эрсдэлтэй хэвээр байна.

Европын Холбоо, Эстони, БНСУ, Сингапур улсуудын дата төвийн хөгжлийн бодлого, урамшууллын тогтолцоог харьцуулан үзэхэд дата төвийн хөрөнгө оруулалтыг татах, дижитал эдийн засгийг хөгжүүлэхэд зөвхөн татварын хөнгөлөлтөөс илүүтэйгээр зохицуулалтын тогтвортой орчин, найдвартай дэд бүтэц, хүний нөөцийн чадавх, инновацыг дэмжсэн бодлогын цогц арга хэмжээ чухал болох нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын нийтлэг онцлог нь өгөгдлийн чөлөөт урсгал, хөрөнгө оруулалтад ээлтэй зохицуулалт, найдвартай эрчим хүч, харилцаа холбооны дэд бүтэц, чадварлаг хүний нөөц, инновацын туршилтын орчин (сэндбокс), төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг уялдуулан хэрэгжүүлж байгаа явдал юм. Харин улс орнууд өөрсдийн онцлогт тулгуурлан ялгаатай хөшүүргүүдийг ашиглаж байна. Тухайлбал, Европын Холбоо нэгдсэн зах зээл, өгөгдлийн чөлөөт урсгалын эрх зүйн орчныг бүрдүүлсэн бол Эстони улс төрийн цахим үйлчилгээ, бизнес эрхлэх таатай орчноороо өрсөлдөж байна. БНСУ татварын болон бүсчилсэн урамшууллын бодлогыг идэвхтэй ашиглаж байгаа бол Сингапур улс чанарт суурилсан, тогтвортой хөгжлийг эрхэмлэсэн зохицуулалтын загварыг хэрэгжүүлж байна.

Мөн дата төвийн хөгжил нь дангаараа нийтийн мэдээллийн дэд бүтцийн асуудал бус, харин хиймэл оюун, үлэн тооцоолол, их өгөгдөл, дижитал үйлчилгээний экосистемийн суурь нөхцөл болохыг эдгээр улсын туршлага харуулж байна. Иймд дата төвийн эрэлт хэрэгцээ нь бодлогын зорилтот салбаруудын хөгжлөөс шууд хамааралтай бөгөөд өгөгдөлд суурилсан эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого давхар хэрэгжих шаардлагатай юм. Дата

төвийн өрсөлдөх чадвар нь татварын бодлогоос гадна урт хугацааны бодлогын тогтвортой байдал, эрчим хүчний хүртээмж, өгөгдлийн засаглалын чанар, хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлэх зохицуулалтын орчноор тодорхойлогдож байгаа бөгөөд Монгол Улс эдгээр хүчин зүйлсийг цогцоор нь хөгжүүлснээр бүс нутгийн хэмжээнд дата төвийн шинэ төв болох боломжтой байна.

--- oOo ---

ӨГӨГДЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Удиртгал, үндэслэл, шаардлага:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд дараах зорилт, арга хэмжээг 2021-2030 онд хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

а/“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.21-д “Их өгөгдөлд суурилсан, алгоритмын болон өндөр давтамжтай арилжааны платформыг нэвтрүүлэн хөрөнгийн зах зээл дэх технологийн дэвшлийг тогтмол хөгжүүлнэ.” гэж, 4.5.2-т “Инновац, технологи нэвтрүүлэх, мэдлэг хуваалцах чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.” гэж, 4.6.10-т “Мэдлэгийн эдийн засгийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.” гэж;

б/мөн уг арга хэмжээний 5.3.1-д “Мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.” гэж, 5.3.5-д “Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно.” гэж, 5.5.1-д “Хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж, хөгжүүлнэ.” гэж;

в/түүнчлэн уг арга хэмжээний 6.4.4-т “Бохирдол, хаягдлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, цэвэр үйлдвэрлэл, хэмнэлттэй хэрэглээг эдийн засгийн хөшүүргээр дэмжинэ.” гэж, 7.5.8-д “Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, уян болон хатуу дэд бүтцийг хөгжүүлнэ.” гэж, 7.5.26-д “Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож, хөгжүүлнэ.” гэж, 9.5.17-д “Газар зүйн байршлын давуу талаа ашиглан олон улсын “Мэдээллийн дата төв”-ийг байгуулна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн”-ийн 10.2-т “Өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар дижитал эдийн засгийг нэмэгдүүлнэ.” гэж, 10.2.1.1-д “Олон улсын дата төвийн чөлөөт бүс бий болгох замаар мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-

2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.3.2.4-т "Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, үүлэн тооцоолуур, блокчейн, юмсын интернэтийг төрийн үйл ажиллагаа, үйлчилгээнд хэрэглэж болох чиглэлүүдийг тодорхойлж, судалгааны ажлуудыг санхүүжүүлж, үе шаттай туршилтын төслүүдийг эхлүүлнэ. Төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжинэ." гэж, 4.3.3.1-д "Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого, зохистой хэрэглээний талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно." гэж тодорхойлсон.

Энэхүү бодлогын хүрээнд төрийн байгууллагын үйл ажиллагааны явцад бүрдүүлэн ашиглаж байгаа өгөгдөл, мэдээллийг нэгтгэн, нөхцөл байдлыг дүгнэх, үнэлгээний үр дүнд их өгөгдөл бий болгоход шаардлагатай арга, хэрэгслийг тодорхойлох зорилгоор "Их өгөгдлийн сан" үүсгэх шийдвэрийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 403 дугаар тогтоолоор баталсан.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлээр "өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин ашиглах талаар эрх зүйн орчныг бүрдүүлэх, Монгол Улсад эрчим хүчний хэмнэлттэй "Ногоон дата төв" байгуулах бэлтгэл ажлыг хангах талаар" үүрэг болгосны дагуу төрийн цахим мэдээллийн нэгдсэн санг зөвхөн өгөгдөл цуглуулах, хадгалах зориулалтаар бус, харин эдийн засаг, инновац, эрдэм шинжилгээ, төрийн үйлчилгээ болон хувийн хэвшлийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд аюулгүй, чанартай, үр ашигтайгаар ашиглуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүсэж байна.

Монгол Улсад өгөгдөл, мэдээлэл, цахим засаглал, хүний хувийн мэдээлэл, кибер аюулгүй байдал, мэдээллийн технологийн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, төр-хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой харилцаа хэд хэдэн бие даасан хуулиар хэсэгчлэн зохицуулагдаж байгаа боловч өгөгдлийн дэд бүтэц, засаглал, өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах процессын цогц зохицуулалт бүрдээгүй. Тухайлбал:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль нь нийтийн мэдээлэл, мэдээллийн сан, нээлттэй өгөгдөл, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийн харилцааг зохицуулдаг боловч нээлттэй өгөгдлөөс цааших бүтээгдэхүүн хөгжүүлэлт, лиценз, төлбөр, өгөгдөл, өгөгдлийн бүтээгдэхүүн солилцох мэдээллийн систем, өгөгдлийн бүтээгдэхүүн солилцоо, хяналт-хариуцлагын харилцааны зохицуулалт тусгагдаагүй;
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль нь хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангах үндсэн хамгаалалтын зохицуулалтыг агуулсан бөгөөд хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох боломжгүй, нэргүйжүүлсэн, нэгтгэсэн, хувийн бус, үйлдвэрлэлийн болон нээлттэй өгөгдөлд суурилсан өгөгдлийн бүтээгдэхүүний талаарх харилцаанд хамааралгүй;
- Кибер аюулгүй байдлын тухай хууль нь кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хамгаалах суурь

зохицуулалт тул өгөгдөл, өгөгдлийн бүтээгдэхүүн солилцох мэдээллийн систем, дата төв, үүлэн тооцооллын үйлчилгээ, хиймэл оюун ухааны тооцоолол, хэрэглээний програмын интерфейс, харьцах хэсэг, аудитын мөр зэрэг дэд бүтцийн шаардлагуудыг тусгайлан зохицуулах шаардлагатай.

Иймд өгөгдлийн дэд бүтэц, эрх зүйн үндэс болон өгөгдлийн засаглалыг бүрдүүлж, өгөгдлийн чанар, аюулгүй байдал, хүртээмж, найдвартай халдашгүй байдлыг баталгаажуулах замаар өгөгдлийг ашиглах, солилцох, боловсруулах, дахин ашиглах, өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах харилцааг бие даасан хуулиар зохицуулах хууль зүйн шаардлага үүсэж байна.

Тухайлбал, төрийн байгууллагуудын мэдээллийн сангууд харилцан уялдаа холбоо муутай, өгөгдлийн стандарт нэгдмэл биш, өгөгдөл солилцох эрх зүйн үндэслэл тодорхой бус байгаа нь мэдээллийн давхардал үүсгэж, иргэн, хуулийн этгээдээс ижил мэдээллийг олон дахин шаардах нөхцөл бүрдүүлж байна.

Мөн өгөгдлийн ангилал, чанарын удирдлага, өгөгдөл эзэмшигч болон хэрэглэгчийн эрх, үүрэг, өгөгдөл хуваалцах нөхцөл, хариуцлагын тогтолцоо зэрэг асуудал салангид зохицуулагдсан байдаг. Үүнээс шалтгаалан төрийн байгууллагуудын өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, цахим үйлчилгээний хөгжил, өгөгдлийн эдийн засгийг хөгжүүлэх боломж хязгаарлагдаж байна.

Өгөгдлийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа өгөгдлийн засаглал, нээлттэй өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдал, өгөгдөл солилцооны чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн туршлага, стандартыг судалж харгалзан үзсэн.

Дэлхийн хэмжээнд өгөгдлийн хурдацтай өсөлт болон технологийн дэвшил нь өгөгдлийн төвүүдийн дэд бүтцийг өргөжүүлэх, их өгөгдлийн зах зээлийг эрчимтэй хөгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж байна. Тодруулбал, өгөгдлийн урсгалын хэмжээ 2024 онд 149 зеттабайт байсан бол 2028 онд 394 зеттабайт болж өсөх төлөвтэй байгаа нь өгөгдөл хадгалах, боловсруулах эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, одоогоор үйл ажиллагаа явуулж буй 11,000 гаруй өгөгдлийн төвийг улам өргөжүүлэхэд хүргэж байна. Энэхүү өсөлтөд хиймэл оюуны хөгжил чухал нөлөө үзүүлж байгаа бөгөөд ирэх 5-10 жилийн хугацаанд үүлэн технологид суурилсан өгөгдлийн төвүүдийн хүчин чадлыг 200 гигаваттаас давуулахад түлхэц болно.

Дэлхийн их өгөгдлийн зах зээл 2023 онд 327.26 тэрбум ам.доллараар үнэлэгдсэн ба 2024-2030 оны хооронд жилд дунджаар 14.9 хувиар өсөхөөр тооцоолол гарсан нь өгөгдлийн хэрэглээ, хиймэл оюуны дэвшил, зах зээлийн тэлэлт хоорондоо нягт уялдаатайгаар өгөгдлийн дэд бүтцийн хөгжлийг шинэ шатанд гаргаж байна.

Тандан судалгааны хүрээнд Европын Холбоо, Бүгд Найрамдах Эстони улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Сингапур зэрэг улсуудын өгөгдлийн засаглалыг өнөөгийн нөхцөл байдал, SWOT шинжилгээ болон

өгөгдлийн бодлогод туссан үр дүн, үзүүлэлтийг жишээ болгон судалж, үр дүнг тоймлон оруулсан.

Олон улсад өгөгдлийг хэрхэн хамгаалах талаар зохицуулалт хийдэг байсан бол сүүлийн жилүүдэд өгөгдөл нь дангаар хөрөнгө болж, өгөгдлийн хүртээмжийг нэмэгдүүлж өгөгдөлд хандах, дамжуулах, солилцохтой холбоотой нарийвчилсан зохицуулалт хийх шаардлага үүсээд байна. Үүнтэй холбоотой Европын холбоо ("EU") нь Data Governance Act (2022) болон Data Act (2023)-аар өгөгдлийн хуваалцах, зуучлагч, болон өгөгдлийн зах зээлийн бүтэц тогтоосон цогц эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Харин дийлэнх улсын хувьд (БНСУ, Сингапур, АНУ-ын Калифорни муж гэх мэт) EU шиг нэгдмэл өгөгдлийн засаглалын тусгай хууль бус, өгөгдөл солилцохтой холбоотой зарчмыг Хүний хувийн мэдээлэл хамгаалахтай холбоотой суурь хууль болон салбарын зохицуулалтад суурилан зохицуулж байна.

Хүснэгт. Олон улсын өгөгдлийн хууль, эрх зүй, бодлого зохицуулалтын харьцуулсан судалгаа

Улсын нэр	Хууль, эрх зүйн орчин	Өгөгдлийн стандарт, шаардлага	Өгөгдөл нэгтгэх технологи, дэд бүтэц	Өгөгдлийн аюулгүй байдал	Хүний нөөцийн чадавх
Европын холбоо	Өгөгдлийн засаглалын хууль, Өгөгдөл хамгаалах ерөнхий журам (GDPR), Нээлттэй өгөгдөл болон нийтийн мэдээллийн дахин ашиглах тогтоол, Европын холбооны өгөгдлийн стратеги	Дундын төв нь өгөгдлийн бүх удирдлагыг хийх бөгөөд европын өгөгдлийн стандартыг давхар мөрдөнө.	Дундын төв байгуулагдаж замаар дэд бүтцийг бий болгоно. Мөн шаардлагатай технологийн судалгаанд хөрөнгө оруулалт хийдэг байна.	Өгөгдөл хамгаалах ерөнхий журам болон бусад хууль эрх зүйн хүрээнд өгөгдлийн аюулгүй байдлыг хангана.	Өгөгдлийн чадвар олгох, иргэдээ хувийн мэдээллээ хамгаалах, захиран зарцуулах чадвар олгох ажлуудад хөрөнгө оруулалт хийх замаар хүний нөөцөө бэлдэнэ гэсэн байна.
Эстони	1990-ээд оны сүүлээс эхлэн цахим засаглалын суурь хууль эрхзүйн орчныг бүрдүүлсэн. Хувийн мэдээллийн хамгааллын хууль, Улсын мэдээллийн сангуудын тухай хууль, Кибер аюулгүй байдлын хууль	Дижитал нийгмийн санаачилгыг эхлүүлснээр дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн.	Байгууллага өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх дундын тооцоолох төв ашиглах	Байгууллага бүр өгөгдлийн аюулгүй байдлаа хангана.	Дэд бүтэц болон хүний нөөцийн сургалтад хөрөнгө оруулалт хийнэ.

БНСУ	Нээлттэй өгөгдлийн хууль, Өгөгдөл хамгаалах хууль, Хувийн мэдээллийг хамгаалах хууль (Personal Information Protection Act, PIPA)	Өгөгдөл бүрт стандарт боловсруулан мөрдүүлсээр ирсэн, PIPA	Нэгдсэн платформ үүсгэх замаар дэд бүтцийг бий болгосон	Хууль, стандартын хүрээнд байгууллага бүр хангаж ажилладаг	Өгөгдлийн чадваруудыг тодорхойлж бүх түвшний сургалтын байгууллагаар өгөгдлийн чадвар олгох сургалт явуулахад дэмжлэг үзүүлнэ.
Сингапур	Public Sector (Governance) Act, Хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (Personal Data Protection Act, PDPA)	Хууль эрх зүйн хүчтэй тогтолцоо нь нийцтэй хэрэгжиж, байнга хянагдаж, шинэчлэгддэг.	Өгөгдөл авах, боловсруулах платформ бий болгох	Төрийн бүх байгууллага мөрдөх өгөгдлийн аюулгүй байдлын стандарт бий болгох	Өгөгдлийн удирдлагын оффис төрийн албан хаагчдад зориулсан сургалт хийх туслалцааг үзүүлнэ.

- **Европын холбоо (EU):** Өгөгдлийн засаглал, зах зээлийн бүтэц, зуучлалыг зохицуулсан «Data Governance Act» (2022) болон «Data Act» (2023) зэрэг бие даасан хуулиудын цогц системтэй. Төрөөс хамааралгүй, бие даасан хувийн өгөгдлийн зуучлагчаар дамжуулан өгөгдөл солилцох загварыг ашигладаг бөгөөд бизнесийн өгөгдөл дамжуулах төлбөрийг үл ялгаварласан, бодит зардалд суурилсан байхаар хуульчилсан. Төрийн байгууллага хувийн өгөгдөлд хязгааргүй нэвтрэх эрхгүй бөгөөд зөвхөн онцгой нөхцөл байдал (гамшиг гэх мэт) болон нийтийн ашиг сонирхлын томоохон төслийн хүрээнд хатуу шалгуураар хандах зохицуулалттай6

- **АНУ (Калифорни муж):** Европын холбоо шиг нэгдмэл тусгай хуульгүй боловч CCPA болон CPRA актуудын хүрээнд хэрэглэгчийн мэдээллээ цуглуулах, гуравдагч этгээдээс татгалзах эрхийг (Opt-Out) DROP платформоор дамжуулан CPRA агентлаг хянадаг. Өгөгдлийг «биет бус хөрөнгө» хэмээн үзэж, төрөөс бүртгэлжүүлсэн өгөгдлийн брокеруудаар (Data broker) дамжуулан зах зээлийн зарчмаар төлбөртэй худалдах, солилцох практик нийтлэг байдаг. Төрийн байгууллагад мэдээлэл гаргаж өгөхдөө нэгжлэг хийх зөвшөөрөлтэй байх, эсхүл сүүлийн нэг жилд ямар байгууллагад мэдээлэл ил болгосноо зохицуулагч байгууллагад бүртгүүлэх шаардлага тавьдаг6

- **Сингапур улс:** Инновацийг дэмжихийн зэрэгцээ хувийн мэдээллийг хамгаалах хариуцлагын тогтолцоог тэнцвэржүүлсэн PDPA (2012) хуульд суурилсан бодлого хэрэгжүүлдэг. Засгийн газраас санаачилсан боловч үйл ажиллагаа нь хувийн компани дээр явагддаг SGTraDex зэрэг салбарын түншлэлийн дундын платформоор дамжуулан өгөгдлийг хадгалахгүйгээр зөвхөн техникийн солилцоо хийх боломжийг бүрдүүлсэн. Өгөгдлийг хувийн болон хувийн бус (нэрийг нууцалсан) гэж ангилдаг бөгөөд хувийн бус өгөгдлийг зах зээлийн зарчмаар, гэрээний үндсэн дээр харьцангуй чөлөөтэй арилжаалахыг зөвшөөрдөг.

- **Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ):** Их өгөгдөлтэй холбоотой тусгайлсан хуульгүй бөгөөд мэдээлэл солилцох харилцааг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (PIPA) болон салбарын зохицуулалтаар

зохицуулдаг. Төрийн оролцоотой, төрийн өмчийн K-DATA платформ нь байгууллагуудын өгөгдлийг өөр дээрээ төвлөрүүлэхгүйгээр хооронд нь солилцох, арилжаалах боломжийг олгодог. Хүнийг таних боломжгүй болгож боловсруулсан өгөгдлийг (Pseudonymous Data) мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр статистик, судалгааны зорилгоор ашиглах, дамжуулах нарийвчилсан зохицуулалттай.

Дээрх улс орнуудад Өгөгдлийн удирдлагын тухай хууль, Өгөгдлийн тухай хуулиар өгөгдөл хуваалцах ажиллагааг сайн дурын үндсэн дээр, итгэмжлэгдсэн зуучлагч байгууллагуудаар дамжуулан аюулгүй байдлаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хэрэглэгчийн өгөгдөлд хандах эрхийг өргөжүүлж, бизнес хоорондын өгөгдөл солилцоонд тодорхой үүрэг, зохицуулалтыг бий болгосон. Төрийн байгууллагууд хувийн хэвшлийн өгөгдөлд бүрэн, хязгааргүй нэвтрэх эрхгүй бөгөөд зөвхөн онцгой нөхцөл (жишээлбэл, гамшиг, нийтийн ашиг сонирхлын шаардлага)-д хатуу шалгуур, үндэслэлтэй, зорилгодоо нийцсэн байх зарчмын дагуу хязгаарлагдмал хэмжээнд хандах боломжтой байхаар зохицуулсан. Харин бусад нийтийн ашиг сонирхлын зориулалттай мега төслүүдийн хувьд өгөгдөл эзэмшигч байгууллага нь өртөгт суурилсан, үндэслэл бүхий ашиг нэмсэн төлбөртэйгөөр дамжуулна гэж заасан.

Түүнчлэн Европын холбооны загвар нь өгөгдлийн урсгалыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хувийн нууц, бизнесийн нууц, өрсөлдөөний шударга байдлыг хамгаалах тэнцвэрт тогтолцоог бий болгох зорилготой бөгөөд төр бүх бизнесийн өгөгдөлд бүрэн хандах, эсхүл өгөгдлийг төвлөрүүлэн төр хянах эрхтэй гэсэн ойлголт байхгүй байна.

Дээрх нөхцөл байдал, судалгаа, зөвлөмжид тулгуурлан Өгөгдлийн тухай анхдагч хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслүүд, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгаа, баримт бичгүүдийг боловсруулсан.

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Өгөгдлийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/63 дугаар тушаалаар төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулж байгуулсан.

Хуулийн төслийг боловсруулах хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Өгөгдлийн тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалсан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон холбогдох зардлын тооцоолол, хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт орох хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслийн эхний хувилбарт санал авахаар Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд 2026 оны 05 дугаар сарын 22-ноос 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хооронд байршуулан иргэд, олон нийтээс санал авсан. Мөн

холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэд, олон нийтээс ирүүлсэн саналыг тусган дахин боловсруулалт хийж тухай бүрд Мэдээллийн технологийн нэгдсэн холбоо, Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци, Монголын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж шийдэл нийлүүлэгчдийн холбоо, ДАМА Монголиа Чаптер - Монголын дата менежментийн мэргэжлийн холбоонд хүргүүлж, санал, шүүмжийг авч ажилласан.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг иргэд, олон нийт, сонирхлын бүлэг, мэргэжлийн холбоодын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд 2026 оны 6 дугаар сарын 12-19-ны өдрүүдэд Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчид, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид, дата төвийн үйл ажиллагаа эрхлэгчид, арилжааны банк, финтек, хэвлэл мэдээллийн төлөөллийг оролцуулан нийт 3 удаагийн хэлэлцүүлгийн хүрээнд оролцогчдоос гаргасан саналыг, хуулийн төсөлд тусгаад байна.

Мөн хуулийн төсөлд санал авахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Засгийн газрын гишүүдэд 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/644 дугаартай, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Үндэсний Статистикийн хорооноос санал авахаар 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 02/1125 дугаартай, 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 01/708, 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 01/762 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлж, саналыг хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн төсөлд зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалт:

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйл болон холбогдох судалгаанд үндэслэн өгөгдөл, мэдээллийг хуваалцах, ашиглах, дахин ашиглах эрх зүйн үндсийг тогтоож, өгөгдлийн аюулгүй байдал, чанар, хүртээмжийг хангах, өгөгдөлд суурилсан инновац, үйлдвэрлэлийг дэмжих асуудлыг цогцоор нь шийдвэрлэсэн Өгөгдлийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийн зорилго нь өгөгдлийн дэд бүтэц, эрх зүйн үндэс болон өгөгдлийн засаглалыг бүрдүүлж, өгөгдлийн чанар, аюулгүй байдал, хүртээмж, халдашгүй байдлыг хангах замаар өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хуулийн төсөл нь 6 бүлэг, 25 зүйлтэй байна. Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу бүлэг тус бүрээр багцлан дараах байдлаар танилцуулъя. Үүнд:

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хуулийн нийтлэг үндэслэлд хуулийн зорилт, өгөгдлийн тухай хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, нэр томьёоны тодорхойлолт, өгөгдлийн харилцаанд баримтлах зарчмыг тусгасан.

Хуулийн зорилго нь өгөгдлийн дэд бүтэц, засаглалыг бүрдүүлж, түүнийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн. Төрийн болон албаны нууц, батлан хамгаалах, тагнуулын үйл ажиллагаанаас бусад өгөгдлийн эргэлтийн харилцааг (үүсгэхээс устгах хүртэл) иж бүрэн зохицуулна.

Европын Холбооны «Data Act» (2023)-ийн нэгэн адил өгөгдлийг зөвхөн захиргааны бүртгэл биш, эдийн засгийн үнэ цэн үүсгэгч “бие даасан хөрөнгө” гэж тодорхойлсон. Нэр томъёог машин унших боломжтой байх, мета өгөгдөл зэрэг технологийн төвийг сахисан (Future-proof) хэлбэрээр OECD-ийн Өгөгдлийн засаглалын зөвлөмжид нийцүүлэн томъёолсон.

Хуулийн төслийг «Өгөгдлийн тухай хууль» гэж ерөнхийлөн томъёолсон нь манай улсын хууль эрх зүйн орчинд өгөгдөл, мэдээллийн харилцааг сууриар нь зохицуулах анхдагч (анхдагч систем үүсгэгч) зохицуулалтыг хийж буйтай холбоотой. Энэхүү нэршлийг сонгосон эрх зүй, практикийн гол үндэслэлүүд:

1. Манай улсад өмнө нь мэдээллийн технологи, цахим хөгжлийн харилцааг хэсэгчилсэн байдлаар зохицуулж байсан бол энэ хууль нь өгөгдлийн эргэлтийг (үүсэх, цуглуулах, боловсруулах, ашиглах, солилцох, устгах) бүхэлд нь хамарсан анхны системлэг хууль юм. Нэршлийг явцууруулахгүйгээр “Өгөгдөл” гэж ерөнхийлөн томъёолсноор төр, хувийн хэвшил, иргэн хоорондын мэдээлэл солилцооны бүх загварыг нэг дор тусгах хууль зүйн боломжийг олгож байна.

2. Нийтийн мэдээлэл, хувийн болон бизнесийн өгөгдлийг харилцан хамааралтай, уялдуулан зохицуулахын тулд “нийтийн мэдээлэл” эсвэл “хувийн мэдээлэл” гэх мэт хязгаарлагдмал нэршил ашиглалгүй, тэдгээрийн язгуур ойлголт болох “өгөгдөл” гэсэн нэр томъёог сонгосон.

3. Технологи өдөр бүр хувьсан өөрчлөгдөж, их өгөгдөл (Big Data), хиймэл оюун ухаан (AI) эрчимтэй хөгжиж байна. Хуулийг ямар нэгэн тодорхой платформ, систем эсвэл явцуу салбараар нэрлэвэл технологийн шинэчлэлийг дагаж хуульд ойр ойрхон нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсдэг. Харин ерөнхий нэршил нь хууль зүйн хувьд технологийн хувьсалд уян хатан, ирээдүйн харилцааг зохицуулах чадамжтай “төвийг сахисан” суурь тогтолцоог бүрдүүлнэ.

4. Дэлхий дахинд өгөгдлийг “шинэ зууны газрын тос” буюу эдийн засгийн бие даасан хөрөнгө, стратегийн нөөц гэж үзэх болсон. Европын Холбооны «Data Act», «Data Governance Act» зэрэг жишгүүд нь мэдээллийг зөвхөн захиргааны хэрэгсэл биш, харин засаглал болон эдийн засгийн бие даасан объект гэж үзэж байна.

Мөн энэ бүлэгт өгөгдлийн чанар, аюулгүй байдал, нээлттэй байдал болон дэд бүтцийн найдвартай байдлыг хангасан 9 суурь зарчим, Дата төвийн үйл ажиллагааны хязгаарлалтыг тогтоосон. Энэхүү зохицуулалт нь OECD, Европын Холбооны GDPR, Data Act зэрэг олон улсын жишигт нийцүүлэн, өгөгдөлд суурилсан эдийн засгийг дэмжих, хүний эрх, үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн болно.

Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн өгөгдлийн засаглалын зарчмуудыг хуульчлах нь цахим үйлчилгээний найдвартай байдал, төрд итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх суурь болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЭЦ, ӨГӨГДЛИЙН САН

Тус бүлэгт өгөгдлийн дэд бүтцийг тодорхойлж, төрийн их өгөгдөл, өгөгдлийн санг мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, кодын дагуу үүсгэх, сангаас ашиглах зориулалтаас нь шалтгаалж өгөгдлийг ангилж, хүртээмжтэй ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгаж, төрийн болон нийтийн өгөгдлийг цэгцлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах дараах суурь зохицуулалтыг бий болгож байна. Тухайлбал;

1.Төрийн их өгөгдлийн дэд бүтэц: Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг өгөгдөл солилцооны нэгдсэн систем болгон өргөжүүлнэ.

- Өгөгдлийг аюулгүй боловсруулах, солилцох, хадгалах мэдээллийн системийн нэгдэл байна.
- Кибер аюулгүй байдал, хандалтын хяналт, шифрлэлтийн системүүд багтана.
- Хандалт, дамжуулалтын үйл ажиллагааны аудит логийг заавал хөтөлнө.
- Өгөгдөл солилцооны дундын платформ болон нэгдсэн каталог ажиллана.
- Архитектур, техникийн нөхцөлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд батална.

2.Өгөгдлийг ашиглах нөхцөл, нууцлалын түвшнээс нь шалтгаалж 4 чиглэлээр ангилна.

- Нээлттэй өгөгдөл: Иргэн, хуулийн этгээд шууд ашиглах боломжтой мэдээлэл байна.
- Хязгаарлалттай өгөгдөл: Хуульд заасан тусгай нөхцөлөөр хандах өгөгдөл юм.
- Хаалттай өгөгдөл: Төрийн болон байгууллагын нууцад хамаарах өгөгдөл хамаарна.
- Нөхцөлт хандалттай өгөгдөл: Гэрээ, зөвшөөрлийн дагуу тодорхой зориулалтаар ашиглах өгөгдөл юм.
- Хандалтын эрхийг өгөгдлийн ангиллыг харгалзан Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.

3.Өгөгдлийг эмх цэгцгүй цуглуулахыг хориглож, нэгдсэн ангилал, стандартад оруулна.

- Хуулийн чиг үүрэг, гэрээ, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлөөр үүсгэнэ.
- Мета өгөгдлийн бүртгэл: Сан бүр нэр, хариуцагч, шинэчлэх давтамж, хадгалах хугацааны бүртгэлтэй байна.
- Давтагдашгүй түлхүүр: Өгөгдлийн мөр бүрийг ялгах, нээлттэй өгөгдөлтэй холбох түлхүүр талбартай байна.

- Тогтвортой байдал: Түлхүүр талбарыг өөрчлөхгүйгээр урт хугацаанд хэрэглэнэ.
- Давхардалгүй байх зарчим: Анхдагч эх сурвалжийн мэдээллийн санг давхардуулан үүсгэхийг хориглоно.

4.Төр, хувийн хэвшлийн дундын өгөгдлийн сан: Хувийн хэвшлийн өгөгдлийг төрийн өгөгдөлтэй уялдуулан арилжааны болон инновацын зорилгоор ашиглах үүд хаалгыг нээнэ.

- Төр, хувийн хэвшил хамтран дундын өгөгдлийн сан үүсгэж болно.
- Мэдээлэл хариуцагчийн хүсэлт, ЦХИХХЯ-ны саналыг үндэслэн Засгийн газар шийдвэр гаргана.
- Иргэн, хувийн хэвшил гэрээ эсвэл лицензийн үндсэн дээр сайн дураар өгөгдөл нийлүүлж болно.
- Гэрээний нөхцөл: Төлбөр, аюулгүй байдал, өгөгдлийг устгах, буцаан татах нөхцөлийг гэрээнд заавал тусгана.

Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт олон улсын дэвшилтэт туршлага, жишгийг дараах байдлаар нутагшуулан тусгалаа:

Европын Холбооны “Data Governance Act” жишиг: Төрийн их өгөгдлийн дэд бүтэц, өгөгдлийн ангиллын засаглалыг тодорхойлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн дурын өгөгдлийн хандив (Data altruism)-ийн зохицуулалтыг эрх зүйн хувьд баталгаажуулсан.

Эстони улсын “X-Road” загвар: Өгөгдөл солилцооны дундын систем болон мета өгөгдлийн бүртгэлийг системүүдийн харилцан ажиллах чадвар (interoperability)-т суурилан боловсруулсан.

Сингапурын “SGTraDex” болон БНСУ-ын “K-DATA” систем: Өгөгдлийг нэгдсэн каталогт оруулж, хэрэглээний программчлалын интерфейс (API) ашиглан аюулгүй, тасралтгүй солилцох нөхцөлийг бүрдүүлсэн.

Төр, хувийн хэвшлийн түншлэл (Data Sharing): Төр болон хувийн хэвшил сайн дурын болон гэрээний үндсэн дээр хамтран дундын өгөгдлийн сан үүсгэх эрх зүйн зохицуулалтыг нээж, датад суурилсан инновацыг хурдасгах хөшүүрэг бий болгосон.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ӨГӨГДЛИЙН ЭРГЭЛТ

Гуравдугаар бүлэгт өгөгдлийн эргэлт буюу өгөгдөл үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, ашиглах, солилцох, дамжуулах, хадгалах, нөөцлөх, устгахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.

Өгөгдлийг үүсгэх, цуглуулах: Зөвшөөрөл, хууль ёсны үндэслэлд суурилсан, олон улсын стандартад нийцсэн өгөгдлийн засаглалыг хуульчилсан. Энэхүү зохицуулалт нь хувийн мэдээллийн хамгаалалт, дата менежментийн

техникийн шаардлага, онцгой байдлын үеийн төрийн эрх болон дата арилжааны эрх зүйн үндсийг тодорхойлж буй цогц заалт юм.

Өгөгдөл ангилах, боловсруулах, хадгалах: Өгөгдөл ангилах, боловсруулах, хадгалах үйл ажиллагаанд нэгдсэн стандарт тогтоож, хувь хүний нууцлал, аюулгүй байдал болон өгөгдлийн нээлттэй байдлыг баталгаажуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Мөн өгөгдлийг устгах, өөрчлөх боломжгүйгээр бүртгэх (audit log), үйл явцыг баримтжуулах, мэдээллийг инновац, бизнесийн эргэлтэд оруулах шаардлагыг тусгасан.

Өгөгдөл солилцох, дамжуулах, ашиглах, дахин ашиглах: Хиймэл оюун ухааны сургалтад өгөгдөл ашиглахад ялгаварлан гадуурхахгүй байх, хүнийг дахин тодорхойлох эрсдэлээс сэргийлэх, мөн иргэн өөрийн өгөгдлийг үнэ төлбөргүй зөөвөрлөн авах (Data Portability) зэрэг онцгой эрхийг баталгаажуулсан.

Өгөгдлийг зөөвөрлөх эрх (Right to data portability) болон өгөгдлийг хамгийн багаар цуглуулах (Data minimization) зарчим нь Европын Холбооны GDPR-ийн суурь зохицуулалт бөгөөд Европын Холбооны Олон нийтийн салбарын мэдээллийн удирдамж (EU Open Data Directive)-ийн хамгийн чухал концепц болох эдийн засаг, инновацийн эргэлтэд хамгийн өндөр үр ашиг авчирдаг өгөгдлүүд буюу “өндөр үнэ цэнэтэй өгөгдлийн бүрдэл” (High-value datasets)-ийг үндэсний хууль тогтоомжид нутагшуулсан.

Өгөгдлийг архивлах, нөөцлөх, устгах: Өгөгдлийг архивлах, нөөцлөх, устгах харилцааг кибер аюулгүй байдал, байгууллагын тасралтгүй ажиллагааны стандартад нийцүүлэн зохицуулж, өгөгдлийг шифрлэн нөөцлөх, хугацаа нь дууссан буюу хууль бус өгөгдлийг нөхөн сэргээх боломжгүйгээр бүрэн устгах, үйл явцыг баримтжуулах хариуцлагыг тусгасан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ДАТА ТӨВ

Тус бүлэгт өгөгдлийг туршилтын орчинд ашиглах зохицуулалтыг бий болгох, Монгол Улсад дотоодын болон гадаадын дата төв (ногоон дата төв), үндэстэн дамнасан олон улсын дата төвийн үйл ажиллагааг эрхлэх, уг үйл ажиллагааг Монгол Улсын чөлөөт бүсэд эрхлэхтэй холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, тэдгээрт хадгалж буй өгөгдлийн халдашгүй байдлыг хангахтай холбоотой тусгай дэглэм бүхий харилцааг тусгасан.

Дэлхийн улс орнууд өгөгдлийн бие даасан, хараат бус байдлыг өөрсдийн геополитик, эдийн засгийн онцлогт тохируулан ялгаатай загвараар хэрэгжүүлдэг бөгөөд хуулиар зохицуулах нэг гол харилцаа нь өгөгдөл хадгалах дэд бүтэц болох дата төвийн харилцаа бөгөөд эрчим хүчний бие даасан байдал (Power Sovereignty), харилцаа холбооны сүлжээний бие даасан байдал (Network Sovereignty), хууль, эрх зүйн хараат бус байдлыг (Legal Sovereignty) нэгэн зэрэг хангасан “Sovereign by Design” загварыг Монгол Улсад бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорьсон.

- **Гадаад этгээдийн өгөгдлийг хамгаалах (Эрх зүйн баталгаа):** Монгол дахь дата төвд байршуулсан гадны иргэн, компанийн өгөгдөлд Монголын хууль хяналтын байгууллага (цагдаа, ТЕГ гэх мэт) дур мэдэн нэвтрэх, серверт үзлэг хийх, хураах, үйл ажиллагааг нь зогсоохыг хатуу хориглосон. Энэ нь гадаадын хөрөнгө оруулагчдад тус улсад үйлчилгээ эрхэлж байгаа гадаад дата төвд хадгалж байгаа гадаад өгөгдөл нь Монголд бүрэн аюулгүй, төрөөс халдашгүй байх итгэлийг өгөх заалт юм.

- **Халдашгүй байдлын үл хамаарах нөхцөл (Хязгаарлалт):** Дээрх хамгаалалт нь хязгааргүй биш. Хэрэв тухайн өгөгдлийг терроризм, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, төрлөөр устгах, олон улсын кибер гэмт хэрэгт ашиглаж байгаа нь олон улсын гэрээгээр нотлогдвол Монгол Улс халдашгүй байдлыг цуцалж, шалгах эрхтэй болно. Энэ нь Монгол Улсыг гэмт хэрэгтнүүдийн өгөгдлөө нуух “нуувч” болохоос сэргийлсэн хамгаалалт юм.

- **Олон улсын хамтын ажиллагаа (Процесс):** Гадаад этгээдийн өгөгдлийг шалгах, мэдээлэл авах, эрх зүйн туслалцаа үзүүлэх бүх харилцааг Монголын дотоодын хуулиар бус, зөвхөн Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенцын дагуу (жишээ нь, Кибер гэмт хэргийн тухай Будапештийн конвенц гэх мэт) албан ёсны сувгаар шийдвэрлэнэ.

Дээрх гурван заалт нь Монгол Улс “Бид гадны өгөгдлийг төрийн оролцоогүйгээр халдашгүй хадгалж чадна, гэхдээ дэлхий нийтийн эсрэг ноцтой гэмт хэргийг өмгөөлөхгүй.” гэсэн тэнцвэртэй, олон улсын жишигт нийцсэн мессежийг дэлхийн технологийн салбарт өгч байна. Түүнчлэн Монгол Улсыг бүс нутгийн өгөгдөл дамжуулах зангилаа (Data Hub) болгож, “Дижитал торгоны зам” болон “Цахим элчин сайдын яам” (Digital Embassy)-ыг бүрдүүлэх геополитик, эдийн засгийн стратегийн ач холбогдолтой зохицуулалтуудыг тусгасан.

Мөн энэхүү бүлгээр транзит урсгалын аюулгүй байдлыг олон улсын гэрээгээр баталгаажуулж, интернэтийн гурваас доошгүй бие даасан гарцыг бий болгон, үүлэн технологид суурилсан найдвартай дэд бүтцийг ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж, байгаль орчинд ээлтэй, сэргээгдэх эрчим хүч ашиглах “Ногоон дата төв”-үүдийг татварын болон санхүүгийн бодлогоор дэмжихээр тусгасан.

Монгол Улсад гадаадын дата төвийн үйлчилгээ эрхлэхэд “Үр ашгаас хуваалцах” гэрээ байгуулж, халдашгүй байдлын төлбөр, экспортолсон өгөгдөл болон эрчим хүчний хэрэглээнээс татвар авч, ногоон технологи, ноу-хау дамжуулахыг хуульчилж байна. Энэ нь төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулснаар гадаадын дата төвд тусгай хамгаалалтын дэглэм үйлчлэх эрх зүйн баталгааг бүрдүүлж буй цогц зохицуулалт юм.

ТАВДУГААР БҮЛЭГ: ӨГӨГДЛИЙН ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

Тус бүлэгт өгөгдлийн харилцаанд оролцогч, тэдгээрийн бүрэн эрх, чиг үүргийг тодорхойлж, өгөгдлийн засаглалын тогтолцоог бэхжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан.

Өгөгдлийн засаглалыг улс төрийн шийдвэр, салбарын бодлого, хөндлөнгийн хяналт болон техникийн хэрэгжилт гэсэн дөрвөн түвшинд нарийн зааглаж, бодлого тодорхойлох яам болон чанарын аудит хийх Статистикийн хороог салгаж өгсөн нь төрийн их өгөгдлийг хамгаалах болон эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн цогц засаглалын бүтэц бий болж байна.

- **Монгол Улсын Засгийн газар:** Өгөгдлийн засаглал, хөгжлийн нэгдсэн бодлого, ногоон технологи нэвтрүүлэх стратегийг баталж, төсөв болон санхүүгийн дэмжлэг, баталгааг шийдвэрлэнэ.

- **Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:** Төрийн их өгөгдлийн нэгдсэн каталог, стандартыг боловсруулах, салбарын хэрэгжилтийг зохион байгуулах, гомдол маргааныг шийдвэрлэх зэрэг бодлогын удирдлагаар хангана.

- **Үндэсний өгөгдлийн зөвлөл:** Ерөнхий сайдын дэргэд ажиллаж, салбар дундын бодлогын уялдааг хангах, стратегийн хэрэгжилтийг үнэлэх, хувийн хэвшлийг дэмжих зөвлөмж гаргана. Зөвлөлийн бүрэлдэхүүнд төрөөс гадна хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, хүний эрхийн байгууллагууд орох тул төрийн нэг яамны дэргэд байхаас илүү Ерөнхий сайдын ивээл дор хараат бусаар ажиллах нь өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулахад олон улсын жишигт (жишээ нь, Сингапур, Эстони улсын загвар) нийцнэ.

- **Үндэсний өгөгдөл эрхлэгч (Үндэсний статистикийн хороо):** Үндэсний хэмжээнд мета өгөгдлийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, өгөгдлийн ангиллыг мөрдүүлэн, төрийн байгууллагуудын өгөгдлийн чанарт үнэлгээ, аудит хийнэ. Олон улсад Үндэсний статистикийн байгууллагуудыг зөвшөөрөгдсөн өгөгдлийн чанарын аудит хийх, стандарт тогтоох үүрэг бүхий “Өгөгдлийн засаглалын удирдагч” (Chief Data Officer / Data Steward) болгон өөрчилдөг НҮБ болон Дэлхийн банкны зөвлөмж, шинэ хандлагыг Монгол Улсын институцийн бүтэц рүү хөрвүүлэн буулгасан.

- **Үндэсний дата төв:** Дэд бүтцийн тасралтгүй, аюулгүй ажиллагааг хариуцаж, шифрлэлт болон хандалтын бүртгэлийг хамгаалж, өгөгдлийг тогтмол нөөцлөн сэргээх техникийн бэлэн байдлыг хангана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ: МАРГААН ШИЙДВЭРЛЭХ, ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Өгөгдлийн өмчлөл, гэрээний маргааныг арбитраар шийдвэрлэх боломжийг нээж, өгөгдлийн тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага болон маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулсан.

Дата төвийн хариуцлагыг чангатгаж, зөрчил гаргасан хуулийн этгээдийг өндөр дүнгээр торгох хариуцлагын тогтолцоо нь ЕХ-ны *GDPR* болон АНУ-ын Калифорни мужийн *CCPA* актын санхүүгийн шийтгэлийн загварт суурилсан бөгөөд энэ нь өгөгдлийн зах зээлд бизнесийн итгэлцэл үүсгэх суурь нөхцөл болдог.

ӨГӨГДЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ДАГАЛДУУЛАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, өмчийн эрхийг хамгаалах, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэх эрх чөлөөг баталгаажуулах, үндэсний аюулгүй байдлыг хангах суурь зарчимд нийцүүлэн боловсруулсан. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн хүний эрх, хувийн мэдээлэл, хувийн нууц, мэдээлэл хайх, хүлээн авах эрх, шинжлэх ухаан, технологи, цахим худалдаа, кибер аюулгүй байдал, хөрөнгө оруулалттай холбоотой нийтлэг зарчимд харшлахгүй. Зохицуулалтын арга барил нь хүний эрх болон эрсдэлд суурилсан, ил тод, ялгаварлалгүй, хариуцлагатай, кибер аюулгүй байдлыг хангасан байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг тус тус боловсруулсан.

Дээрх 5 хуулийн гол агуулга, хуулийн зохицуулалтыг дараах байдлаар тусгасан.

1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүйгээр, тэдгээрийн эрэлт, хэрэгцээг харгалзан эдийн засаг, бизнесийг дэмжих, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй, хязгаарлалттай болон хаалттай мэдээллийн хүн, хуулийн этгээд, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нээлттэй өгөгдөл болгож ашиглах талаар зохицуулсан хэдий ч хаалттай, хязгаарлалттай мэдээллийг тодорхой нөхцөл, эрх, зөвшөөрлийн хүрээнд дахин ашиглах эрх зүйн зохицуулалтгүй байгааг шийдвэрлэх зохилгоор Өгөгдлийн тухай хуулийн төслийг боловсруулж, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд туссан өгөгдөлтэй холбоотой суурь зохицуулалттай хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулсан.

2.Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүн”-ийн 10.2-т “Өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар дижитал эдийн засгийг нэмэгдүүлнэ.” гэж, 10.2.1.1-д “Олон улсын дата

төвийн чөлөөт бүс бий болгох замаар мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.” гэж заасан.

Өгөгдлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хоёрдугаар хэсгийн 4-т өгөгдлийг туршилтын орчинд ашиглах зохицуулалтыг бий болгох, Монгол Улсад дотоодын болон гадаадын дата төв (ногоон дата төв), үндэстэн дамнасан олон улсын дата төвийн үйл ажиллагааг эрхлэх, уг үйл ажиллагааг Монгол Улсын чөлөөт бүсэд эрхлэхтэй холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, тэдгээрт хадгалж буй өгөгдлийн халдашгүй байдлыг хангахтай холбоотой тусгай дэглэм бүхий харилцааг хуулийн төсөлд тусгах талаар заасан.

Түүнчлэн Өгөгдлийн тухай хуулийн төсөлд дата төвийн үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай дэд бүтцийг бий болгохтой холбоотой гадаадын этгээдийн хүсэлтийг шийдвэрлэх ажлыг нэг цонхны үйлчилгээгээр явуулахаар заасан бөгөөд уг нэг цонхны үйлчилгээг төрийн цахим үйлчилгээ хариуцсан төрийн захиргааны байгууллага эрхлэхээр заасан нь хуулийн нэг гол зохицуулалт юм.

3.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай

Дата төвд уригдан ажиллаж байгаа, нарийн мэргэжлийн инженер, техникийн гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөхөөр хуульчилж байна. Үүний зэрэгцээ цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тодорхойлсон дата төвийн үйлчилгээ эрхлэгч ажил олгогчид ажиллах гадаад ажилтны тоо, хувь хэмжээнд хуульд заасан гадаад ажилтан ажиллуулах квотын хязгаарлалт хамаарахгүй байх зохицуулалтыг шинээр суулгалаа. Учир нь глобал дата төвүүдийн дэд бүтцийг угсрах, удирдах, кибер аюулгүй байдлыг хангах нарийн мэргэжлийн инженерүүд дотоодын зах зээлд дутагдалтай байгааг нөхөх зорилгоор энэхүү хөнгөлөлтийг тусгасан бөгөөд уг зохицуулалт нь Монгол Улсыг олон улсын интернэтийн транзит урсгал дамжсан, бүс нутгийн “Дата хаб” (Data Hub) болон хөгжихөд шаардлагатай дэлхийн хэмжээний ноу-хау, технологийн соёлыг шуурхай нэвтрүүлэх хөдөлмөрийн зах зээлийн нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэн.

Мөн урт хугацаандаа гадаадын өндөр зэрэглэлийн инженерүүд дотоодын залуу боловсон хүчнийг ажлын байран дээр сургаж, чадавхжуулах чухал ач холбогдолтой.

Технологийн салбарт дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн нарийн мэргэжлийн инженерүүд (жишээ нь Cisco, AWS, Oracle-ийн дээд түвшний сертификаттай мэргэжилтнүүд) заавал Монголын боловсролын байгууллагуудаар явж дипломоо баталгаажуулах гэж цаг алдахгүй. Төрийн баталсан жагсаалтад орсон сертификаттай гадаад инженерийг дата төв урьж ажиллуулахад, түүний гэрчилгээг үндэслэн ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх санхүүгийн хөнгөлөлт нь идэвхжинэ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

Өгөгдлийн тухай хуулиар тогтоосон суурь хориглолтууд болон дата төвийн үйл ажиллагааны аюулгүй байдлын шаардлагыг зөрчсөн үйлдэлд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгож, Зөрчлийн тухай хуульд шинэ зүйл, заалт нэмж оруулж байна. Тухайлбал, хүнийг таних боломжгүй болгож боловсруулсан өгөгдлийг (Pseudonymous Data) зөвшөөрөлгүйгээр буцаан сэргээх, хүнийг дахин тодорхойлох, эсхүл дата төв нь хэрэглэгчийн өгөгдлийг зөвшөөрөлгүй хуулбарлах, устгах, өөрчлөх үйлдлүүдийг зөрчилд тооцно. Эдгээр ноцтой зөрчлийг гаргасан хүнийг 2,000 нэгж (2 сая төгрөг), хуулийн этгээдийг 20,000-аас 50,000 нэгж (20-оос 50 сая төгрөг) хүртэлх мөнгөн дүнгээр торгох эрх зүйн санхүүгийн тусгайлан зааж өглөө.

Өгөгдлийн зах зээлд бизнесийн итгэлцэл үүсгэх, иргэдийн цахим халдашгүй байдлыг хамгаалахад ийм хэмжээний санхүүгийн бодит хариуцлага зайлшгүй хэрэгцээтэй юм. Энэхүү зохицуулалт нь хувийн болон бизнесийн өгөгдлийг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, дата төвүүдийн хариуцлагыг олон улсын жишигт (ЕХ-ны GDPR) ойртуулах суурь алхам болно.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай

Зөрчлийн тухай хуульд шинээр нэмэгдсэн өгөгдлийн харилцаатай холбоотой зөрчлүүдийг харьяалан шалгах, шийдвэрлэх эрх бүхий байгууллага, улсын байцаагчийн чиг үүргийг тус хуульд нарийвчлан зааж байна. Өгөгдлийн нууцлал алдагдах, дата төвийн үйл ажиллагааны журам зөрчигдөх зэрэг технологийн нарийн мэргэжлийн зөрчлүүдийг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтын улсын байцаагч шалган шийдвэрлэхээр харьяалал тогтоолоо.

Шалгалтын явцад техникийн болон кибер аюулгүй байдлын нарийн шинжилгээ хийх шаардлага гардаг тул зөрчил шалгах ажиллагаанд салбарын эксперт, мэргэжлийн байгууллагыг татан оролцуулах эрх зүйн боломжийг нээж, зөрчлийг мэргэжлийн түвшинд, шуурхай, үнэн зөв тогтоож, хэрэглэгч болон бизнесийн эрх ашгийг цаг алдалгүй хамгаалахад чиглэгдэнэ.

Дээрх дэлгэрэнгүй танилцуулгыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасны дагуу боловсрууллаа. Дээрх дагалдах хуулийг Өгөгдлийн тухай хуулийн төслийн нэр томьёо, үг хэллэг, утга найруулгатай уялдуулан нэмэлт, өөрчлөлт оруулан боловсруулсан.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ӨГӨГДЛИЙН ТУХАЙ /Анхдагч хууль/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь өгөгдлийн дэд бүтэц, эрх зүйн үндэс болон өгөгдлийн засаглалыг бүрдүүлж, өгөгдлийн чанар, аюулгүй байдал, хүртээмж, халдашгүй байдлыг хангах замаар өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулахад оршино.

2 дугаар зүйл.Өгөгдлийн хууль тогтоомж

2.1.Өгөгдлийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Статистикийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт өгөгдлийг үүсгэх, цуглуулах, ангилах, боловсруулах, хадгалах, ашиглах, дахин ашиглах, солилцох, дамжуулах, нөөцлөх, устгах үйл ажиллагаа (цаашид “өгөгдлийн эргэлт” гэх)-г зохицуулах, түүнчлэн дата төвийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдон үүсэх харилцаанд үйлчилнэ.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан харилцаанд оролцогч төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, өмчийн хэлбэрээс үл хамааран дотоод, гадаадын хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага энэ хуулийг нэгэн адил дагаж мөрдөнө.

3.3.Энэ хууль дараах харилцаанд үйлчлэхгүй:

3.3.1.төрийн болон албаны нууцад хамааруулсан өгөгдлийн эргэлттэй холбоотой харилцаа;

3.3.2.үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, тагнуул, гүйцэтгэх ажил болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах өгөгдлийн эргэлттэй холбоотой харилцаа;

3.3.3.иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хэрэгцээнд зориулж, арилжааны бус зорилгоор өгөгдөл ашиглахтай холбоотой харилцаа.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“дата төв” гэж өгөгдлийг боловсруулах, дамжуулах, солилцох, хадгалах, нөөцлөх үүрэг гүйцэтгэж байгаа харилцаа холбоо, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж болон тэдгээрийг байрлуулах физик болон виртуал дэд бүтэц бүхий барилга байгууламжийн стандарт шаардлага хангасан орон зайг;

4.1.2.“дата төвийн үйлчилгээ үзүүлэгч” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийг;

4.1.3.“гадаадын дата төв” гэж энэ хуульд заасан тусгай дэглэм үйлчлэх энэ хуулийн 4.1.1-д заасан дата төвийг;

4.1.4.“гадаадын дата төвийн үйлчилгээ үзүүлэгч” гэж гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж энэ хуулийн 4.1.2-т заасан үйлчилгээ үзүүлэхээр энэ хуулийн 13.12-т заасан гэрээ байгуулсан этгээдийг;

4.1.5.“мета өгөгдөл” гэж өгөгдлийн эх сурвалж, бүтэц, агуулга, үүсгэсэн болон өөрчлөлт, шинэчлэлтийн огноо, гарал үүслийн бүртгэл, өгөгдлийн эзэмшигч, ашиглах нөхцөл зэргийг тодорхойлсон тайлбарыг;

4.1.6.“нээлттэй өгөгдөл” гэж машин унших боломжтой хэлбэрээр түгээгдсэн хэсэгчилж авах боломжтой бүтэцлэгдсэн нийтийн мэдээллийг;

4.1.7.“өгөгдөл” гэж хүн, хуулийн этгээд, эд зүйл, үйл явдал, үйл ажиллагаатай холбоотой баримт, шинж чанар, төлөв байдлыг цахим системд боловсруулах, дамжуулах, хадгалахад зориулан бичвэр, тэмдэгт, тоо, дүрс, дуу авиа болон бусад хэлбэрээр илэрхийлсэн техникийн дүрслэлийг;

4.1.8.“өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүн” гэж өгөгдлийг нэгтгэх, ангилах, дүн шинжилгээ хийх болон бусад аргаар боловсруулсан, тодорхой хэрэглээ, үнэ цэн бүхий, ашиглах, солилцох, түгээх, дахин ашиглах боломжтой мэдээллийг;

4.1.9.“өгөгдлийн дэд бүтэц” гэж өгөгдөл, мэдээлэл цуглуулах, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох зориулалт бүхий техник, программ хангамж, мэдээллийн сүлжээ, мэдээллийн системийн цогцыг;

4.1.10.“өгөгдлийн каталог” гэж өгөгдлийн бүрдэл, мета өгөгдөл, эх сурвалж, эзэмшигч, хариуцагч, ангилал, чанарын үзүүлэлт, гарал үүслийн бүртгэл,

ашиглах нөхцөл, хандах эрх, хэрэглээний программчлалын интерфeйс холболтын мэдээллийг нэгтгэн хадгалах, хайлт хийх боломж бүхий системийг;

4.1.11.“өгөгдлийн сан” гэж мета-өгөгдөл, хандалтын хязгаарлалт, солилцох болон дахин ашиглах боломжийг хамарсан цогц өгөгдлийг;

4.1.12.“өгөгдлийн эзэн” гэж тухайн өгөгдлийг анх үүсгэсэн, эсхүл хууль болон гэрээний үндсэн дээр хувийн бус өгөгдлийг өмчлөх, захиран зарцуулах эрхийг шилжүүлж авсан этгээдийг;

4.1.13.“өгөгдөл эзэмшигч” гэж өгөгдлийн эзнээс олгосон зөвшөөрөл, эсхүл хуульд заасан чиг үүргийн дагуу өгөгдлийг цуглуулах, боловсруулах, ашиглах эрх бүхий этгээдийг;

4.1.14.“өгөгдөл хариуцагч” гэж хууль, гэрээ, эрх бүхий этгээдийн шийдвэр, эсхүл хууль ёсны бусад үндэслэлээр өгөгдлийн харилцааны зорилго, нөхцөл, шаардлагыг тодорхойлж, түүний хууль ёсны байдал, аюулгүй байдал, чанар болон өгөгдлийн эргэлтийн хэрэгжилтийг бие даан, эсхүл бусадтай хамтран зохион байгуулж байгаа этгээдийг;

4.1.15.“өгөгдөл хэрэглэгч” гэж хуульд заасан үндэслэл, нөхцөлийн дагуу өгөгдлийг ашиглаж байгаа этгээдийг;

4.1.16.“өгөгдөл боловсруулагч” гэж өгөгдөлд дүн шинжилгээ хийх, системчилсэн хэлбэрт оруулж байгаа эрх бүхий этгээдийг;

4.1.17.“өгөгдөл нийлүүлэгч” гэж өгөгдлийг өгөгдлийн хэрэглэгч, өгөгдлийн дэд бүтцэд нийлүүлж байгаа энэ хуулийн 4.1.12, 4.1.13, 4.1.14, 4.1.16-д заасан этгээдийг;

4.1.18.“өгөгдөл зуучлагч” гэж хүн, хуулийн этгээдээс өгөгдлийг өгөгдөл хэрэглэгчид хүргэх шаардлага хангасан этгээдийг;

4.1.19.“өгөгдөл зуучлалын үйлчилгээ” гэж өгөгдөл эзэмшигч болон өгөгдөл хэрэглэгч талуудын хооронд хууль зүйн болон техникийн харилцан хамаарал тогтоох замаар өгөгдлийг хамтран ашиглах, солилцох, нэгтгэх боломжийг олгож байгаа, өгөгдөл хэрэглэгчээс хараат бус дижитал платформ болон техникийн дэд бүтцийн үйлчилгээг;

4.1.20.“хэрэглээний програмчлалын интерфeйс” гэж мэдээллийн систем, програм хангамж хооронд өгөгдлийг автоматаар, тасралтгүй солилцох, харилцан ажиллагааг хангах зориулалттай цахим холболтын шийдлийг.

5 дугаар зүйл.Өгөгдлийн харилцаанд баримтлах зарчим

5.1.Өгөгдлийн харилцаанд дараах зарчмыг баримтална:

байх; 5.1.1.өгөгдөл нь анхдагч болон хууль ёсны эх сурвалжид тулгуурласан

5.1.2.үнэн зөв, бүрэн бүтэн, чанартай байх;

5.1.3.тодорхой зорилготой байх;

5.1.4.хэмжигдэхүйц байх;

5.1.5.хуульд өөрөөр зааснаас бусад төрийн их өгөгдөл нээлттэй, хүртээмжтэй байх;

5.1.6.хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол, хувийн нууцыг хамгаалсан, харилцан итгэлцэл, ёс зүйг баримталсан байх;

5.1.7.өгөгдлийн нууцлал, кибер аюулгүй байдлыг хангасан байх;

байх; 5.1.8.өгөгдлийн дэд бүтэц нь найдвартай, тасралтгүй ажиллагаатай

5.1.9.өгөгдлийн зохицуулалт нь инноваци, өгөгдөлд суурилсан эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн байх.

5.2.Дата төвийн үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдал, хүний эрх, нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхгүй байх зарчмыг баримтална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЭЦ, ӨГӨГДЛИЙН САН

6 дугаар зүйл.Төрийн их өгөгдлийн дэд бүтэц

6.1.Монгол Улс төрийн их өгөгдлийн дэд бүтэцтэй байна.

6.2.Төрийн их өгөгдлийн дэд бүтэц нь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хооронд өгөгдлийг аюулгүй, найдвартай, харилцан уялдаатай боловсруулах, солилцох, ашиглах, дахин ашиглах, хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн мэдээллийн систем, мэдээллийн сүлжээний нэгдэл байна.

6.3.Төрийн их өгөгдлийн дэд бүтэц нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.1-д заасан нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарна.

6.4.Энэ хуулийн 6.2-т заасан мэдээллийн систем нь төрийн их өгөгдөл, түүнийг хадгалах, боловсруулах, солилцох, ашиглах системээс бүрдэнэ.

6.5.Энэ хуулийн 6.4-т заасан системийн үйл ажиллагаа дараах хэсгүүдтэй:

6.5.1.кибер аюулгүй байдлыг хангах, хандалтын хяналт, шифрлэлт болон тасралтгүй ажиллагааг зохицуулах систем;

6.5.2.өгөгдөл ашиглалт, хандалт, дамжуулалтын үйл ажиллагааны бүртгэл (лог, аудит лог);

6.5.3.өгөгдлийн нэгдсэн каталог болон мета өгөгдлийн бүртгэлийн систем;

6.5.4.өгөгдөл солилцооны дундын систем;

6.5.5.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 26.1-д заасан төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ болон шаардлага хангасан бусад сүлжээ.

6.6.Төрийн их өгөгдлийн дэд бүтцийн архитектур, түүнд холбогдох техникийн нөхцөл, шаардлагыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Техникийн нөхцөл, шаардлагад тагнуулын байгууллагын саналыг авна.

7 дугаар зүйл.Төрийн их өгөгдөл

7.1.Монгол Улсын төрийн их өгөгдөл нь (цаашид “Төрийн их өгөгдөл” гэх) Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан нийтийн мэдээллийн сан дахь өгөгдөл болон бусад өгөгдлийн бүрдэл байна.

7.2.Төрийн их өгөгдлийн системд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27.1-д заасан мэдээллийн сангаас өгөгдөл нийлүүлэх бөгөөд хувийн өмчийн хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хүн сайн дурын болон гэрээний үндсэн дээр өгөгдөл нийлүүлж болно.

7.3.Төрийн их өгөгдлийн системд өгөгдлийг мета өгөгдлийн бүртгэл, мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, код, стандартын дагуу нийлүүлнэ.

7.4.Төрийн их өгөгдлийн системд өгөгдөл цуглуулах, солилцоход өгөгдөл солилцооны дундын системтэй холбогдож, ашиглана.

Тайлбар: “өгөгдөл солилцооны дундын систем” гэж төрийн болон хувийн хэвшлийн мэдээллийн систем хооронд өгөгдөл, мета өгөгдлийг багцлан дамжуулах, солилцох, удирдах зориулалт бүхий технологийн нэгдсэн платформыг;

7.5.Төрийн их өгөгдлийг дараах байдлаар ангилна:

7.5.1.нээлттэй өгөгдөл;

7.5.2.хязгаарлалттай өгөгдөл;

7.5.3.хаалттай өгөгдөл;

7.5.4.нөхцөлт хандалттай өгөгдөл.

Тайлбар: “нөхцөлт хандалттай өгөгдөл” гэж гэрээ, зөвшөөрлийн дагуу зориулалтын хязгаарлалт болон бусад нөхцөлтэйгөөр ашиглах өгөгдлийг хэлнэ.

7.6.Энэ хуулийн 7.5-д заасны дагуу ангилсан төрийн их өгөгдлийг ашиглахад хуульд заасан үндэслэл, ашиглалтын зориулалтыг харгалзан хандалтын эрхийг олгоно.

7.7.Энэ хуулийн 7.5-д заасны дагуу ангилсан өгөгдлийг машин унших, хэрэглээний програмчлалын интерфэйс ашиглан солилцоход энэ хуулийн 6.6-д заасан техникийн нөхцөлийг хангасан байна.

7.8.Төрийн өгөгдлийн систем нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан анхдагч эх сурвалжийн болон мэдээллийн санг давхардуулан үүсгэхийг хориглох зарчимд нийцсэн байна. Системийн бүтэц нь мета өгөгдлийн нэгдсэн каталог, хяналттай хэрэглээний мэдээллийн систем хоорондын холбоос, хандалтын эрхийн удирдлага болон аудитын бүртгэлд суурилсан хэлбэрээр зохион байгуулагдаж, хэрэгжинэ.

7.9.Төрийн өгөгдлийн санд өгөгдөл нийлүүлэх, солилцох, ашиглах хандалтын эрх олгох журмыг энэ хуулийн 7.5-д заасан өгөгдлийн ангиллыг харгалзан Засгийн газар батална.

7.10.Энэ хуулийн 7.2-т заасан сайн дурын үндсэн дээр өгөгдөл нийлүүлэх харилцааг гэрээ, эсвэл өгөгдөл ашиглах зөвшөөрөл (лиценз)-ийн үндсэн дээр зохицуулах бөгөөд гэрээнд ашиглах зорилго, хүрээ, хугацаа, төлбөрийн нөхцөл, аюулгүй байдлыг хангах, өгөгдлийг буцаан татах, устгах нөхцөлийг заавал тусгана.

8 дугаар зүйл.Өгөгдлийн сан үүсгэх, түүнд тавигдах шаардлага

8.1.Хүн, хуулийн этгээд хуульд заасан чиг үүрэг, гэрээ, зөвшөөрөл, мэдээллийн эзний зөвшөөрөл, нийтийн ашиг сонирхол, эсхүл хууль ёсны бусад үндэслэлийн хүрээнд өгөгдлийн сан (цаашид “өгөгдлийн сан” гэх)-г үүсгэж, ашиглах эрхтэй бөгөөд энэ хуулийн 7.3-т заасан нэгдсэн ангилал, код, стандартыг мөрдөж болно.

8.2.Өгөгдлийн санд хадгалагдах өгөгдөл нь нэр, зориулалт, хариуцагч, эх сурвалж, ангилал, ашиглах нөхцөл, шинэчлэх давтамж, хадгалах хугацаа, чанарын үзүүлэлт болон хандалтын нөхцөл бүхий мета өгөгдлийн бүртгэлтэй байна.

8.3.Өгөгдлийн сан дараах шаардлагыг хангана:

8.3.1.өгөгдлийн мөр бүрийг дахин давтагдашгүй байдлаар ялган таних, бусад нээлттэй өгөгдөлтэй холбох, уялдуулан ашиглах боломжтой түлхүүр талбартай байх;

8.3.2.энэ хуулийн 8.3.1-д заасан түлхүүр, талбарыг өөрчлөхгүйгээр урт хугацаанд тогтвортой хэрэглэх;

8.3.3.бусад эх сурвалж бүхий өгөгдөлтэй шууд харилцан хамааралтай ажиллах техникийн нөхцөлийг бүрдүүлсэн байх.

8.4.Төрийн байгууллага нь хувийн өмчийн хуулийн этгээдтэй хамтран Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27.1-д заасан мэдээллийн сангийн өгөгдлийг зөвшөөрөлтэйгөөр болон бусад өгөгдлийг ашиглан дундын өгөгдлийн сан үүсгэж болно.

8.5.Энэ хуулийн 8.4-т заасан дундын өгөгдлийн санг үүсгэхэд нийтийн мэдээллийн санг ашиглуулах мэдээлэл хариуцагчийн хүсэлтийг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

8.6.Өгөгдөл эзэмшигч нь мета өгөгдлийг үнэн зөв, бүрэн, тухай бүр шинэчлэн хөтлөх үүрэгтэй.

8.7.Төрийн байгууллага нь өгөгдлийн каталог болон мета өгөгдлийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, тухай бүр шинэчилнэ.

8.8.Өгөгдлийн каталог болон мета өгөгдлийн бүртгэл нь өгөгдлийг хайх, ашиглах, солилцох, дахин ашиглах боломжийг бүрдүүлэх бөгөөд энэ нь тухайн өгөгдөлд шууд хандах эрхийг үүсгэх үндэслэл болохгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ӨГӨГДЛИЙН ЭРГЭЛТ

9 дүгээр зүйл.Өгөгдөл үүсгэх, цуглуулах

9.1.Өгөгдлийг хууль ёсны эх сурвалжаас хуульд заасан чиг үүрэг, гэрээ, өгөгдөл, өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүн ашиглах лиценз, өгөгдлийн эзний зөвшөөрлийн дагуу үүсгэж, цуглуулна.

9.2.Өгөгдөл үүсгэх, цуглуулахад дараах шаардлагыг хангасан байна:

9.2.1.зорилго, үндэслэлийг зөвшөөрөлд үндэслэн цахим хэлбэрээр баталгаажуулсан байх;

9.2.2.зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хамгийн бага хэмжээний өгөгдлийг цуглуулах;

9.2.3.давхардсан эх сурвалжаас цуглуулахад дахин давтагдашгүй түлхүүр ашиглах;

9.2.4.өгөгдлийг цуглуулахад бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг шалгах.

9.3.Хүний хувийн мэдээлэл агуулсан өгөгдлийг үүсгэх, цуглуулахад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан мэдээллийн эзний зөвшөөрөл, эсхүл хуульд заасан бусад үндэслэлийг баримтална.

9.4.Үндэсний аюулгүй байдлыг хангах, гамшиг, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах зорилгоор төрийн эрх бүхий байгууллага хүн, хуулийн этгээдийн өгөгдөлд хандах ба өгөгдлийг бодит өртгөөр цуглуулж, анх авсан зорилгын хүрээнд ашиглаж, зорилго дуусмагц устгах үүрэгтэй.

9.5.Энэ хуулийн 9.4-т зааснаас бусад тохиолдолд төрийн байгууллага нь шийдвэр гаргах, бодлого төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх болон албан ёсны статистик мэдээлэл бэлтгэх зорилгоор иргэн, хуулийн этгээдийн үүсгэсэн, цуглуулсан өгөгдлийг Статистикийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн, гэрээ, хэлцлийн үндсэн дээр арилжааны нөхцөлөөр худалдан авч болно.

10 дугаар зүйл.Өгөгдөл ангилах, боловсруулах, хадгалах

10.1.Өгөгдөл хариуцагч нь цуглуулсан өгөгдлийг мета өгөгдлийн нэгдсэн каталог, мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, код, стандартын дагуу төрөлжүүлэн ангилж болно.

10.2.Өгөгдлийг нэгтгэх, мэдээллийн хүртээмж, ашиглалтыг нэмэгдүүлэх болон эдийн засаг, бизнес, инновац, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны үйл ажиллагаанд ашиглах болон бусад зорилгоор боловсруулна.

10.3.Өгөгдөл боловсруулах ажиллагаанд дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

10.3.1.урьдчилан тодорхойлсон зорилгод нийцсэн, өгөгдлийн эх сурвалж, боловсруулалтын талаарх мэдээллийг баримтжуулсан байх;

10.3.2.хүний хувийн мэдээллийг боловсруулахад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 16.1-д заасан мэдээллийн эзний эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байх;

10.3.3.өгөгдөлд хамаарах мэдээллийн эзнийг шууд болон шууд бусаар тодорхойлох боломжгүй болгох, эсхүл бусад хэлбэрээр нууцлалыг хангаж нээлттэй өгөгдөл болгон нийтлэх;

10.3.4.өгөгдөлд хийсэн хувиргалт, нэгтгэл, дүн шинжилгээ, боловсруулалтын аргачлал, логик дарааллыг энэ хуулийн 6.5.2-т заасан бүртгэлийн дагуу баталгаажуулах.

10.4.Өгөгдөл хариуцагч нь өгөгдөл ангилах, боловсруулах, хадгалах үйл ажиллагааны аргачлал, логик дараалал, хандалтын түүх болон үйлдлийн бүртгэлийг устгах, өөрчлөх боломжгүйгээр цахим хэлбэрээр хөтлөнө.

10.5.Өгөгдөл боловсруулагч нь боловсруулсан өгөгдлийн үнэн зөв, аюулгүй байдлыг хангаж, тухай бүр шинэчилнэ.

10.6.Өгөгдөл хариуцагч нь хадгалж байгаа өгөгдлийн бүрэн бүтэн, нууцлагдсан байдлыг хангана.

10.7.Өгөгдлийг хадгалахад өгөгдлийн ангилал, ашиглах зорилго, хадгалах хугацаа, кибер аюулгүй байдал, хандалтын эрх, архивын шаардлага болон гэрээ, лицензийн нөхцөлийг баримтална.

11 дүгээр зүйл.Өгөгдөл солилцох, дамжуулах, ашиглах, дахин ашиглах

11.1.Өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор солилцох, дамжуулах, ашиглах, дахин ашиглах ажиллагааг хууль, гэрээ, лиценз, өгөгдлийн эзний зөвшөөрөл, эсхүл эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу энэ хуулийн 7.6-д заасан хандалтын эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ.

11.2.Өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, шинэ технологи, инновацыг турших зорилгоор Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 4.1.6-д заасан зохицуулалтын туршилтын орчин (сэндбокс)-ыг ашиглана.

11.3.Өгөгдөл, өгөгдөлд суурилсан бүтээгдэхүүнийг хууль, гэрээ, лицензийн нөхцөлийн дагуу төлбөртэй, эсхүл төлбөргүйгээр ашиглуулна.

11.4.Лицензийн төрлийг нээлттэй, судалгааны, хязгаарлагдмал, арилжааны, нийтийн ашиг сонирхлын гэсэн ангилалд үндэслэн өгөгдөл эзэмшигч тогтоох бөгөөд жишиг загварыг энэ хуулийн 20-д заасан байгууллага батална.

11.5.Өгөгдлийг анх авсан зорилгоос өөр зорилгоор ашиглах, гуравдагч этгээдэд дамжуулан ашиглуулахад лиценз, өгөгдлийн эзний зөвшөөрлийг дахин авна.

11.6.Хязгаарлалттай, хаалттай өгөгдлийг солилцох, дамжуулах, ашиглахад хууль, гэрээ, лиценз, өгөгдлийн эзний зөвшөөрөл, эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан шаардлага, кибер аюулгүй байдлыг хангана.

11.7.Тодорхойлох боломжгүй болгосон өгөгдлийг бусад өгөгдөлтэй нэгтгэх, эсхүл дүгнэлт гаргах замаар хүн, хуулийн этгээдийг дахин тодорхойлсон бол дахин тодорхойлогдсон өгөгдлийг хандалтыг хязгаарлах техникийн горимоор хамгаална.

11.8.Хиймэл оюун, машин сургалтад суурилсан болон автомат шийдвэр гаргах системд өгөгдлийг ашиглахад дараах шаардлагыг хангасан байна:

11.8.1.сургалтын өгөгдөл, системийн гаралт, үйл ажиллагааны бүртгэл (лог), өгөгдсөн заавар, дүгнэлтийн түүхийг аюулгүй хадгалах, хамгаалах;

11.8.2.хүнийг дахин тодорхойлох, нууц мэдээллийг сэргээх, зан төлөвийг зөвшөөрөлгүй тодорхойлохоос сэргийлэх техникийн шийдлийг нэвтрүүлсэн байх;

11.8.3.тухайн өгөгдөлд хамаарах оюуны өмчийн эрх, бизнесийн нууцыг алдагдуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх;

11.8.4.өгөгдлийг бүрдүүлэх, ашиглах явцад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн байдлаар ялгаварлан гадуурхсан, гажуудуулсан дүгнэлт гаргахаас сэргийлсэн байх.

11.9.Хуульд нийтэд нийтлэхийг заасан болон нээлттэй өгөгдлийг өөрийн цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд нийтэлнэ.

11.10.Нийтлэх өгөгдөл дараах шаардлагыг хангасан байна:

11.10.1.мета өгөгдөлтэй байх;

11.10.2.нийтлэхийн өмнө дахин тодорхойлох эсэхийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байх;

11.10.3.хуульд тусгайлан хамгаалсан мэдээллийг арилгасан, шууд болон шууд бусаар тодорхойлох боломжгүй болгосон байх.

11.11.Нийтэлсэн нээлттэй өгөгдлийг хандахад хялбар, хуулах, эрэмбэлэх, хайлт хийх боломжтой байх, ашиглах нөхцөлийг тодорхойлсон байна.

11.12.Төрийн өгөгдөл хариуцагч өөрийн эзэмшил, удирдлагад байгаа дараах ангиллын өгөгдлийг нээлттэй өгөгдөл болгон нийтлэх үүрэгтэй:

11.12.1.газарзүйн болон орон зайн;

11.12.2.байгаль орчин, дэлхий судлалын;

11.12.3.уур амьсгал, цаг уурын;

11.12.4.албан ёсны статистикийн;

11.12.5.хуулийн этгээд, түүний эцсийн өмчлөлийн;

11.12.6.тээвэр, авто замын хөдөлгөөний;

11.12.7.төрийн үйлчилгээ, улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн;

11.12.8.хуульд заасан бусад.

11.13.Дараах тохиолдолд өгөгдлийг нээлттэй өгөгдөл болгон нийтлэхийг хориглоно:

11.13.1.тухайн өгөгдлөөр дамжуулан хүний хувийн мэдээлэл, бизнесийн нууц ил болох, эсхүл хүн, хуулийн этгээдийг шууд болон шууд бусаар тодорхойлох боломжтой бол;

11.13.2.оюуны өмчийн болон гуравдагч этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчихөөр бол;

11.13.3.төрийн болон албаны нууцад хамаарах;

11.13.4.хуулиар нийтэд нээлттэй болгохыг хязгаарласан бусад.

11.14.Энэ хуулийн 11.13-т заасан үндэслэлээр гаргасан гомдлыг өгөгдөл хариуцагч ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэх бөгөөд гомдлыг хянах хугацаанд тухайн өгөгдөлд хандах хандалт, нийтлэлтийг түр зогсооно.

11.15.Хүн, хуулийн этгээдээс өгөгдлийг ашиглах, дахин ашиглах, эсхүл нийтэд нээлттэй болгох талаар гаргасан хүсэлт, саналыг өгөгдөл хариуцагч хүлээн авч, дараах журмаар шийдвэрлэнэ:

11.15.1.хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдрийн дотор шийдвэрлэж, өгөгдлийг машин унших боломжит хэлбэрээр хангах, эсхүл өгөгдөл ашиглах лицензийн саналыг хүргүүлэх;

11.15.2.нарийн төвөгтэй, өргөн хүрээтэй хүсэлтийг шийдвэрлэх хугацааг үндэслэл бүхий тайлбартайгаар нэг удаа 20 ажлын өдрөөр сунгаж, өргөдөл гаргагчид мэдэгдэх;

11.15.3.хүсэлтээс татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэл, шийдвэрийг өргөдөл гаргагчид цахимаар мэдэгдэх.

11.16.Өгөгдөл солилцох, дамжуулах үйл ажиллагаанд хэрэглээний програмчлалын интерфэйс, эсхүл шаардлага хангасан өгөгдлийн дэд бүтцийг ашиглана.

11.17.Өгөгдөл солилцооны явцад өгөгдөл алдаатай, бүрэн бус, эсхүл хуульд заасан шаардлага хангаагүй нь илэрсэн бол өгөгдөл хэрэглэгч нь өгөгдөл нийлүүлэгч болон өгөгдөл хариуцагчид даруй мэдэгдэж, засварлуулах, шинэчлүүлэх, эсхүл ашиглалтыг шаардлагатай бол түр зогсоох арга хэмжээг авна.

11.18.Хүний хувийн мэдээлэл агуулсан өгөгдлийг хил дамнуулан дамжуулахад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан аюулгүй байдлын шаардлагыг нэгэн адил мөрдөнө.

11.19.Өгөгдлийн эзэн өөрт хамаарах, өөрийн үйл ажиллагааны явцад үүссэн өгөгдлийг өгөгдөл хариуцагчаас бүтэцлэгдсэн, машин унших боломжтой, нийтлэг хэлбэрээр үнэ төлбөргүй авах эрхтэй.

11.20.Өгөгдлийн эзний хүсэлтээр өгөгдөл хариуцагч нь техникийн боломжтой тохиолдолд тухайн өгөгдлийг өөр өгөгдөл хариуцагч, эсхүл үйлчилгээ үзүүлэгчид хэрэглээний программчлалын интерфейс ашиглан шууд, аюулгүй хэлбэрээр шилжүүлнэ.

11.21.Хүний хувийн мэдээлэлд хамаарах өгөгдлийг зөөвөрлөхөд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан үндэслэл, журмыг баримтална.

11.22.Өгөгдлийн эргэлтийн үе шатанд өгөгдлийн чанарыг энэ хуулийн 18.1.4-т заасан аргачлалын дагуу үнэлж болно.

12 дугаар зүйл.Өгөгдлийг архивлах, нөөцлөх, устгах

12.1.Өгөгдлийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасныг баримтлан архивлах ажиллагааг хийнэ.

12.2.Өгөгдлийг алдагдахаас хамгаалах, кибер халдлага, системийн доголдол, гамшиг, үйлчилгээний тасалдлын үед сэргээх боломжийг бүрдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор өгөгдлийг нөөцөлнө.

12.3.Өгөгдөл хариуцагч нь өгөгдлийн ангилал, ач холбогдол, эрсдэлийн түвшин, хадгалах хугацаа, ашиглах давтамж, сэргээх шаардлагыг харгалзан нөөцлөх давтамж, байршил, сэргээх хугацаа, хамгаалалтын горимыг тогтооно.

12.4.Нөөцөлсөн өгөгдөлд үндсэн өгөгдөлтэй адил нууцлал, кибер аюулгүй байдал, хандалтын эрх, шифрлэлт, энэ хуулийн 6.5.2-т заасан бүртгэлийн шаардлага тавигдана.

12.5.Өгөгдлийг дараах тохиолдолд устгана:

12.5.1.өгөгдлийг хуульд заасан үндэслэл, журам зөрчиж үүсгэсэн, цуглуулсан, боловсруулсан, ашигласан болох нь тогтоогдсон, эсхүл хуульд заасан үндэслэлийн дагуу өгөгдлийн эзэн, өгөгдөл эзэмшигч хүсэлт гаргасан;

12.5.2.хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ, эсхүл хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр өгөгдлийг устгахаар заасан;

12.5.3.өгөгдөл хадгалах хугацаа, гэрээ, лиценз, зөвшөөрөл, ашиглах эрхийн хугацаа дуусгавар болсон;

12.5.4.хуульд заасан бусад үндэслэл үүссэн.

12.6.Өгөгдлийг устгахад түүнийг нөхөн сэргээх боломжгүй болгох техникийн нөхцөлийг хангаж, устгалын огноо, үндэслэл, аргачлал, хариуцсан этгээд, устгасан өгөгдлийн ангилал бүхий бүртгэл хөтөлнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ДАТА ТӨВ

13 дугаар зүйл.Дата төвийн үйлчилгээ эрхлэх, эрх зүйн баталгаа

13.1.Монгол Улсад болон гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт дата төвийн үйлчилгээ эрхэлж болно.

13.2.Гадаадын дата төвд байршуулсан гадаад этгээдийн өгөгдөл, мэдээлэл нь халдашгүй байх бөгөөд олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын эрх бүхий байгууллага тухайн дата төвийн өгөгдөлд нэвтрэх, физик болон цахим үзлэг хийх, хураан авах, үйл ажиллагааг нь зогсоохыг хориглоно.

13.3.Энэ хуулийн 13.2-т заасан халдашгүй байдлын баталгаа нь төрлөөр устгах, хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг, терроризм, хүүхдийн эсрэг гэмт хэрэг болон олон улсын кибер гэмт хэрэгтэй тэмцэх конвенцод заасан үйлдэлд тухайн өгөгдлийг ашиглаж байгаа нь Монгол Улсын болон тухайн гадаад улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу урьдчилан тогтоогдсон тохиолдолд үйлчлэхгүй.

13.4.Энэ хуулийн 13.2-т заасан өгөгдөлд хандах, мэдээлэл авах эсхүл эрх зүйн туслалцаа үзүүлэх харилцааг Монгол Улсын Олон улсын гэрээнд заасан нөхцөлийн дагуу зохион байгуулна.

13.5.Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаадын дата төвд тусгай хамгаалалт, халдашгүй байдал, эрх зүйн бусад баталгааг тогтоох асуудлаар олон улсын эрх зүйн харилцааг зохицуулсан Монгол Улсын олон улсын гэрээг гуравдагч улстай байгуулна.

13.6.Хөрш улсын нутаг дэвсгэрээр дамжих гадаадын дата төвийн транзит урсгалын халдашгүй байдлыг хангах зорилгоор хөрш орнуудтай тусгайлсан хэлэлцээ хийж, Монгол Улсын олон улсын гэрээ байгуулна.

13.7.Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаадын дата төвийн сүлжээнд эрх бүхий байгууллагаас олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд хяналт, хязгаарлалт хийхгүй байна.

13.8.Дата төвийн дамжуулах сүлжээний аюулгүй, найдвартай байдлыг хангах, техникийн болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор Монгол Улс нь олон улсын интернэтийн гарцыг газар зүйн болон техникийн хувьд бие даасан, хоорондоо хамааралгүй гурваас доошгүй байхаар зохион байгуулна.

13.9.Монгол Улсын Засгийн газраас өгөгдлийн аюулгүй, тасралтгүй байдлыг хангах зорилгоор гадаад улсын нутаг дэвсгэр дэх дата төвд өгөгдөл байршуулах талаар Монгол Улсын олон улсын гэрээг гуравдагч улстай байгуулж болно.

13.10.Үндэсний аюулгүй байдал, төрийн нууцад хамаарахаас бусад өгөгдлийн санг өгөгдлийн ангилал, кибер аюулгүй байдлын эрсдэлийн болон мэдээллийн аюулгүй байдлын аудитын үнэлгээнд үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэрт байрших дотоодын болон гадаадын дата төв, мөн олон улсын стандартад нийцсэн үүлэн технологийн үйлчилгээ эрхлэгчийн дэд бүтцэд байршуулж болно.

13.11.Дата төвийн үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай дэд бүтцийг бий болгохтой холбоотой гадаадын этгээдийн хүсэлтийг шийдвэрлэх ажлыг нэг цонхны үйлчилгээгээр явуулна. Дата төв байгуулахтай холбоотой хүсэлтэд техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хавсаргасан байна.

13.12.Монгол Улсад дата төвийн үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан гадаадын этгээдтэй үр ашгаас хуваалцах гэрээ байгуулах бөгөөд гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

13.12.1.энэ хуулийн 13.2 болон 13.5-д заасан дата төвийн тусгай хамгаалалт, халдашгүй байдал баталгаажсан тохиолдолд халдашгүй байдлын баталгааны зохицуулалтын төлбөрийг тогтоосон хувь хэмжээгээр улсын төсөвт төвлөрүүлэх;

13.12.2.Монгол Улсын харилцаа холбооны газрын дэд бүтцээс хамааралгүйгээр, нам орбитын болон бусад хиймэл дагуулын сүлжээ ашиглан өгөгдөл дамжуулах, экспортлох үйлчилгээ эрхэлсэн тохиолдолд сүлжээний орон зайн хараат бус байдлыг хангах тусгай үйлчилгээний төлбөрийг экспортлосон өгөгдлийн хэмжээнээс тооцож улсын төсөвт төвлөрүүлэх;

13.12.3.сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан бие даасан эрчим хүчний эх үүсвэрийг бий болгон өөрийн дата төвийг хангаж байгаа бол эрчим хүчний хараат бус байдлын төлбөрийг үүсгэсэн эрчим хүчний хэмжээнээс тооцож улсын төсөвт төвлөрүүлэх;

13.12.4.байгалийн нөөцийг ашиглан бие даасан эрчим хүчний эх үүсвэрийг бий болгон өөрийн дата төвийг хангаж байгаа бол эрчим хүчний хараат бус байдлын төлбөрийг үүсгэсэн эрчим хүчний хэмжээнээс тооцож болон нүүрстөрөгчийн ялгарлыг цэвэр дүнгээр тэг болгох хүртэлх хугацаанд хүлэмжийн хийн ялгаруулалтыг дүйцүүлэх төлбөрийг тус тус улсын төсөвт төвлөрүүлэх;

13.12.5.Монгол Улсын төрийн байгууллага, эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагад дата төвийн тооцоолон бодох, нөөцлөх, хадгалах төхөөрөмжийн тодорхой хувийг үнэ төлбөргүй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

13.12.6.дотоодын эдийн засагт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг өсгөх, гадаад валютын цэвэр урсгалыг нэмэгдүүлэх;

13.12.7.нарийн мэргэжлийн инженер, технологийн мэргэжилтнийг Монгол Улсад бэлтгэх, дотоодын ажлын байрыг тогтвортой нэмэгдүүлэх;

13.12.8.дэвшилтэт технологи, ноу-хау дамжуулах.

13.13.Энэ хуулийн 13.12.1, 13.12.2, 13.12.3, 13.12.4-т заасан өгөөжийн хувь хэмжээг тооцох аргачлалыг Засгийн газар батлах бөгөөд аргачлалд энэ хуулийн 13.12-т заасан төлбөрийг тооцож эхлэх хугацааг заасан байна.

13.14.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32¹.1-д заасан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 13.11-д заасан хүсэлтийг шийдвэрлэхтэй холбоотой ажлыг зохион байгуулах болон энэ хуулийн 13.12-т заасан гэрээг байгуулна.

13.15.Гадаадын дата төв нь энэ хуулийн 13.12-т заасан гэрээг байгуулснаар холбогдох бусад хуулиар тогтоосон хөрөнгө оруулалт, татвар, дэд бүтэц болон үйл ажиллагааны эрх зүйн бусад тусгай баталгаа, хөнгөлөлтийг эдлэх эрх үүснэ.

14 дүгээр зүйл.Ногоон технологи, эрчим хүчний үр ашигтай дата төвд тавигдах шаардлага, дэмжлэг

14.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт шинээр байгуулагдах дата төв нь байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй ногоон технологийг нэвтрүүлэх стратеги төлөвлөгөөтэй байна.

14.2.Энэ хуулийн 14.1-д заасан стратеги төлөвлөгөөнд дата төвийн цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээг нар, салхи, ус, газрын гүний дулаан зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хангах, нүүрстөрөгчийн ялгарлыг цэвэр дүнгээр тэг байлгах зохицуулалтыг тодорхой тусгана.

14.3.Ногоон дата төвд тавигдах шаардлага, эрчим хүчний үр ашиг, нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах технологи нэвтрүүлсэн эсэхийг дараах шалгуурыг харгалзан стандартын дагуу тогтооно:

14.3.1.эрчим хүчний ашиглалтын үр ашгийн стандарт үзүүлэлтийг Засгийн газраас тогтоосон нормоос хэтрүүлэхгүй байх;

14.3.2.энэ хуулийн 14.1-д заасан стратеги төлөвлөгөөг баталсан байх;

14.3.3.цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хуваарилалт, нөөцлөлтийн системийг өөр дээрээ иж бүрэн шийдэх эрчим хүч хадгалах болон ухаалаг эрчим хүчний удирдлагын систем нэвтрүүлсэн байх;

14.3.4.хөргөлтийн эрчим хүчний хэрэглээг бууруулах байгаль орчинд ээлтэй эко-хөргөлт, шингэн хөргөлт, эсхүл дулаан дахин ашиглах шийдлийг нэвтрүүлсэн байх;

14.3.5.эрчим хүчний үр ашгийн үндэсний, эсхүл олон улсын стандарт, техникийн зохицуулалтыг хангасан байх;

14.3.6.хүлэмжийн хийн ялгарлын тооцоо, тайлагнал болон түүнийг бууруулах, нөхөх төлөвлөгөөг баталсан байх.

14.4.Ногоон дата төвийн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор дараах хэлбэрийн зохицуулалтын болон дэд бүтэц, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ:

14.4.1.дата төвийн дэргэдэх сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг эрчим хүчний түгээх сүлжээнд холбох, цахилгаан эрчим хүчний хангамжийн найдваржилтын нэгдүгээр зэрэглэлд хамруулах;

14.4.2.хөрөнгө оруулалтын зардлыг нөхөх хугацаанд тухайн дата төвийн өөрийн үүсгэсэн сэргээгдэх эрчим хүчний илүүдэл урсгалыг төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд давуу эрхтэйгээр худалдан авах нөхцөлөөр хангах;

14.4.3.ногоон зээлд хамрагдахад Засгийн газрын баталгаа гаргах, зээлийн нэн хөнгөлөлттэй нөхцөл бий болгох.

14.5.Ногоон дата төвийг байгуулахад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээг, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн дагуу эрчим хүчний үр ашгийн үнэлгээг тус тус хийлгэсэн байна.

14.6.Энэ хуулийн 14.4.1, 14.4.2-т заасан хөнгөлөлт, чөлөөлөлт, дэмжлэгийг тухайн дата төвийн сэргээгдэх эрчим хүчний ашиглалт, эрчим хүчний үр ашгийн талаарх дүгнэлтийг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн дагуу эдлүүлнэ.

14.7.Ногоон дата төвийн шаардлагыг үнэлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах технологийг баталгаажуулах, энэ хуулийн 14.6-д заасан хамтарсан дүгнэлтийг гаргах нөхцөл, журмыг байгаль орчин, уур амьсгалын болон эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

14.8.Дата төвийн үйлчилгээ эрхлэгч нь байгалийн нөөцийг түшиглэн үйл ажиллагаа эрхэлж байгаа бол нүүрстөрөгчийн ялгарлыг цэвэр дүнгээр тэг болгох хүртэлх хугацаанд хүлэмжийн хийн ялгаруулалтыг дүйцүүлж бууруулах төлбөрийг энэ хуулийн 13.13-т заасныг баримтлан улсын төсөвт төвлөрүүлнэ.

15 дугаар зүйл.Чөлөөт бүсэд дата төвийн үйлчилгээ эрхлэгчид үзүүлэх зохион байгуулалтын дэмжлэг

15.1.Чөлөөт бүсийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөт бүсэд дата төвийн үйлчилгээ эрхлэх хөрөнгө оруулагчид дараах зохион байгуулалтын дэмжлэгийг үзүүлнэ:

15.1.1.дата төвийн төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах төрийн үйлчилгээ, тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөл, дүгнэлт, бүртгэлийг цахим нэг цонхны зарчмаар шуурхай шийдвэрлэх;

15.1.2.дата төвийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах цахилгаан эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, эрчим хүчний хуримтлуур, холболтын техникийн нөхцөл болон диспетчерийн зохицуулалтыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шийдвэрлэх;

15.1.3.дата төвийн харилцаа холбооны сүлжээ байгуулах, дотоод болон олон улсын транзит урсгалын холболт хийх, сүлжээнүүдийн харилцан холболтыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос шийдвэрлэх;

15.1.4.дата төвийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгааны хүрээнд газар, ус хангамж, хөргөлтийн систем болон инженерийн бусад дэд бүтцийг цогцоор шийдвэрлэхэд тухайн чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас дэмжлэг үзүүлэх.

15.2.Энэ хуулийн 15.1.1-д заасан цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалтын журмыг Засгийн газар батална.

16 дугаар зүйл.Өгөгдлийн урсгал, сүлжээний дэд бүтцийн зохицуулалт

16.1.Нам болон дунд тойрог замын хиймэл дагуулын сүлжээ ашиглан өгөгдөл дамжуулах, экспортлох үйлчилгээ эрхлэхэд Монгол Улсын нутаг дэвсгэрт байршилтай газрын станцыг ашиглана. Газрын станцыг ижил төрлийн үйлчилгээ эрхлэгчид дундаа ашиглаж болно.

16.2.Өгөгдлийн дэд бүтцийн холболт, хил дамнасан өгөгдөл солилцох, дамжуулах шинэ технологийг хязгаарлагдмал хүрээнд турших, нэвтрүүлэх зорилгоор зохицуулалтын туршилтын орчин /сэндбокс/-ыг бий болгох бөгөөд түүнийг ажиллуулах, хяналт тавих журмыг Засгийн газар батална.

16.3.Энэ хуулийн 7.5-д заасан нээлттэй ангиллын өгөгдлийн хил дамнасан урсгалд урьдчилсан зөвшөөрлийн дэглэм тогтоохгүй бөгөөд шифрлэлт, гэрээний нөхцөл, баталгаажсан дэд бүтцэд суурилсан эрсдэлийн үнэлгээгээр зохицуулна.

16.4.Хязгаарлалттай болон нөхцөлт хандалттай өгөгдлийн үндсэн хуулбарыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байршуулж, хадгалах бөгөөд нөөц хуулбар, гамшгаас хамгаалах, сэргээх зориулалтаар аюулгүй байдлын шаардлагыг хангасны үндсэн дээр олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсад байршуулж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ ӨГӨГДЛИЙН ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

17 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

17.1.Өгөгдлийн засаглалын талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.өгөгдлийн засаглал, хөгжлийн талаарх төрийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийг хангаж, төрийн их өгөгдлийн дэд бүтцийг хөгжүүлэх стратеги, хөтөлбөрийг батлах;

17.1.2.дата төвийн үйл ажиллагаанд байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй ногоон технологийг нэвтрүүлэх стратеги, хөтөлбөрийг батлах;

17.1.3.төрийн их өгөгдлийн дэд бүтцийг бүрдүүлэх, техникийн хүчин чадлыг өргөтгөхөд шаардагдах хөрөнгө, төсвийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлэх;

17.1.4.ногоон дата төвийн үйлчилгээ эрхлэх этгээдэд Засгийн газрын баталгаа гаргах, ногоон зээлийн нэн хөнгөлөлттэй нөхцөл бий болгох.

18 дугаар зүйл.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

18.1.Өгөгдлийн засаглалын талаар цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1.өгөгдлийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд зохион байгуулах, энэ хуулийн 17.1.1, 17.1.2-т заасан стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, хэрэгжилтийг хангах;

18.1.2.төрийн их өгөгдлийн нэгдсэн каталог хөтлөх;

18.1.3.мета өгөгдлийн бүртгэл, мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, код, стандартыг боловсруулах;

18.1.4.төрийн их өгөгдлийн дэд бүтцэд нийлүүлэх өгөгдлийн чанарын шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн үнэн зөв, бүрэн бүтэн, шинэчлэгдсэн байдлыг харгалзан боловсруулж, энэ хуулийн 20-д заасан байгууллагатай хамтран батлах;

18.1.5.өгөгдөл зуучлалын үйлчилгээ эрхлэгчийн бүртгэл хөтлөх;

18.1.6.төрийн их өгөгдлийн чанар, хүртээмжийн байдалд мэргэжлийн хараат бус байгууллагаар жил бүр батлагдсан арга, аргачлалын дагуу хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, үнэлгээний тайланг Засгийн газар, Их өгөгдлийн үндэсний зөвлөлд танилцуулах;

18.1.7.нээлттэй өгөгдөл бий болгох талаар өгөгдөл хариуцагч, мэдээлэл хариуцагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

18.1.8.төрийн байгууллага хооронд, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд хооронд үүссэн өгөгдөл солилцох, ашиглахтай холбоотой гомдол, маргааныг хүлээн авах, шийдвэрлэх, шаардлагатай бол харьяалах бусад байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх;

18.1.9.Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний тухай хуулийн 21.4.1-д заасан Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдөх мэргэжлийн боловсролын диплом, гэрчилгээтэй дүйцүүлэн тооцох гэрчилгээний жагсаалтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

18.1.10.өгөгдөл солилцооны явцад өгөгдлийн найдвартай байдал, өгөгдлийн ёс зүй, арга зүйн шаардлагыг хангах чиглэлээр өгөгдөл хариуцагчийг зөвлөмжөөр хангах.

19 дүгээр зүйл.Үндэсний өгөгдлийн зөвлөл

19.1.Өгөгдлийн салбар дундын бодлогын уялдааг хангах, үндэсний өгөгдлийн засаглалын стратегийн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний өгөгдлийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллана.

19.2.Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.2.1.өгөгдлийн засаглалын талаарх салбарын стратеги, арга хэмжээний хэрэгжилтийн явцад үнэлгээ хийх, Засгийн газарт санал, зөвлөмж хүргүүлэх;

19.2.2.өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хувийн хэвшлийг дэмжих чиглэлээр зөвлөмж гаргах.

19.3.Зөвлөл нь хүний эрх, цахим хөгжил, кибер аюулгүй байдал, статистик, мэдээллийн технологи, харилцаа холбоо, эрдэм шинжилгээ, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

19.4.Зөвлөлийг Ерөнхий сайд, түүний эзгүйд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн даргалах бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална. Зөвлөлийн Ажлын албаны чиг үүргийг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

20 дугаар зүйл.Үндэсний өгөгдөл эрхлэгч байгууллагын чиг үүрэг

20.1.Үндэсний өгөгдөл эрхлэгч байгууллагын чиг үүрэг (цаашид “Өгөгдөл эрхлэгч” гэх)-ийг Үндэсний статистикийн хороо хэрэгжүүлнэ.

20.2.Өгөгдөл эрхлэгч нь өгөгдлийн засаглалын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.2.1.мета өгөгдлийн бүрдүүлэлт, хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйн зөвлөмж өгөх;

20.2.2.өгөгдлийн ангиллыг үндэсний хэмжээнд мөрдүүлж, хэрэгжилтийг хангуулах;

20.2.3.төрийн байгууллага, хуулийн этгээдийн их өгөгдлийн чанар, стандартын хэрэгжилтэд энэ хуулийн 18.1.4-т заасны дагуу хамтран баталсан нэгдмэл шалгуурыг үндэслэн үнэлгээ өгөх;

20.2.4.өгөгдөл хариуцагч, үйлчилгээ үзүүлэгчид өгөгдлийн засаглал, аюулгүй байдлын стандарт хангасныг гэрчилсэн мэдээллийн итгэлцлийн гэрчилгээ олгох, баталгаажуулах журмыг баталж, хэрэгжүүлэх;

20.2.5.төрийн өгөгдлийн ашиглалт, чанарын төлөв байдлын нэгдсэн тайланг жил бүр гаргаж, Засгийн газар болон Үндэсний өгөгдлийн зөвлөлд хүргүүлэх, Улсын Их Хуралд танилцуулах.

21 дүгээр зүйл.Үндэсний дата төвийн чиг үүрэг

21.1.Төрийн их өгөгдлийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай, аюулгүй ажиллагааг хангах, өгөгдөл хадгалах, нөөцлөх, боловсруулах чиг үүрэг бүхий өгөгдлийн дэд бүтцийг хариуцагч байгууллага Үндэсний дата төв байна.

21.2.Үндэсний дата төв өгөгдлийн харилцаанд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.2.1.төрийн их өгөгдөл, их өгөгдлийн дэд бүтцийн техникийн тасралтгүй, найдвартай, аюулгүй ажиллагааг хариуцах;

21.2.2.төрийн их өгөгдлийг энэ хуулийн 7.1-д заасны дагуу цуглуулах, төрийн шийдвэр гаргалтад зориулж өгөгдлийн дүн шинжилгээ хийх техникийн болон системийн бэлэн байдлыг хангах;

21.2.3.төрийн их өгөгдлийг дамжуулах, солилцоход шифрлэлт, цахим гарын үсэг, хандалтын хяналтын дэвшилтэт технологийн шийдлийг нэвтрүүлэх;

21.2.4.төрийн их өгөгдөлд хандсан үйлдлийн түүх, дамжуулалтын үйл ажиллагааны бүртгэлийг хууль тогтоомжид заасан хугацаанд өөрчлөх боломжгүйгээр хадгалах, хамгаалах;

21.2.5.төрийн байгууллагын өгөгдлийн бүртгэл, мета өгөгдөл, чанар, солилцоо болон аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг эрх бүхий байгууллагын шаардлагаар техникийн түвшинд шалгах, төрийн захиргааны төв байгууллагаас явуулах өгөгдлийн засаглалын үнэлгээнд техникийн дэмжлэг үзүүлэх, дүгнэлт гаргах;

21.2.6.энэ хуулийн 20.2.2-т заасан өгөгдлийн чанарын аудит хийх болон эрх бүхий байгууллагаас хуульд заасан үндэслэлээр шаардсан системийн лог, хандалтын бүртгэл, дамжуулалтын болон техникийн мэдээллийг мэдээллийн аюулгүй байдлын горимын дагуу гаргаж өгөх;

21.2.7.төрийн их өгөгдлийг энэ хуулийн 12.2-т заасны дагуу тогтмол нөөцлөх, системийн доголдлын үед өгөгдлийг бүрэн сэргээх техникийн бэлэн байдлыг хангах.

21.3.Үндэсний дата төв нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27.1-д заасан мэдээллийн сангийн анхдагч өгөгдлийг давхардуулан төвлөрүүлэхгүй бөгөөд өгөгдөл солилцооны давхарга, нөөцлөлт, аюулгүй байдлын дэд бүтцийг хариуцна.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ
МАРГААН ШИЙДВЭРЛЭХ, ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД
ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

22 дугаар зүйл.Маргаан шийдвэрлэх

22.1.Энэ хуулийн 11.14, 18.1.8-д заасан байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргана.

22.2.Өгөгдлийг өмчлөх, захиран зарцуулах эрх бүхий талуудын хооронд байгуулсан гэрээнээс үүссэн арилжааны шинжтэй маргааныг талууд харилцан тохиролцсон бол Арбитрын тухай хуульд заасны дагуу арбитраар шийдвэрлүүлж болно. Нийтийн эрх зүйн болон төрийн их өгөгдөлтэй холбоотой маргаанд энэ хэсэг хамаарахгүй.

23 дугаар зүйл.Хуулиар хориглох үйл ажиллагаа

23.1.Өгөгдлийн харилцаанд дараах үйл ажиллагааг хориглоно:

23.1.1.боловсруулсан, ашигласан өгөгдлийг бусад эх сурвалжтай нэгтгэж хүн, хуулийн этгээдийг дахин тодорхойлох, нууцад хамаарах мэдээллийг сэргээх;

23.1.2.гадаад улсын болон гадаадын хөрөнгө оруулалттай дата төвд үндэсний аюулгүй байдал, төрийн нууцад хамаарах өгөгдлийг байршуулах;

23.1.3.дата төвийн үйлчилгээ үзүүлэгч нь хадгалж байгаа өгөгдөлд зөвшөөрөлгүйгээр хандах, хуулбарлах, өөрчлөх, устгах, гуравдагч этгээдэд дамжуулах, эсхүл гэрээ, лицензийн нөхцөлд зааснаас өөр зорилгоор ашиглах.

24 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

24.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

24.2.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

25 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

25.1.Энэ хуулийг 2027 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/22 дугаар зүйлийн 22.7 дахь хэсэг:

“22.7.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тодорхойлсон дата төвийн үйл үйлчилгээ эрхлэгч ажил олгогчид ажиллах гадаад ажилтны тоо, хувь хэмжээнд энэ хуулийн 22.1-д заасан гадаад ажилтан ажиллуулах квотын хязгаарлалт хамаарахгүй.”

2 дугаар зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн "мэргэжлийн багш, дасгалжуулагч" гэсний дараа “, дата төвд уригдан ажиллаж байгаа, нарийн мэргэжлийн инженер, техникийн гадаад ажилтан” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Өгөгдлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Чөлөөт бүсийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг:

“9.3.Чөлөөт бүсэд дата төвийн үйлчилгээ эрхлэхтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэх харилцаанд Өгөгдлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.11-13.14 дэх хэсэгт заасны дагуу үйлчилнэ.”

2/19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалт:

“19.1.5.Чөлөөт бүсэд дата төвийн үйлчилгээ эрхэлж байгаа этгээдээс Өгөгдлийн тухай хуулийн 13.12-т заасан гэрээний дагуу төвлөрүүлсэн орлого.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Өгөгдлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалт:

“4.1.10“мэдээллийн сан” гэж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон салбарын бусад хуульд заасан чиг үүрэг, бүртгэл, лавлагаа, үйлчилгээ, нотлох баримтжуулалт, хяналт, статистик, бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтад ашиглах зорилгоор мэдээллийг системтэйгээр цуглуулах, хадгалах, шинэчлэх, хамгаалах, ашиглах боломжтойгоор зохион байгуулсан мэдээллийн бүрдэл, эсхүл мэдээллийн системийг;”

2 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт:

“4.1.1.“мэдээллийн систем” гэж хуульд заасан чиг үүрэг, бүртгэл, лавлагаа, үйлчилгээ, хяналт, статистик, бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтад ашиглах мэдээллийг цуглуулах, боловсруулах, хадгалах, шинэчлэх, хамгаалах, дамжуулах, ашиглах ажиллагааг хэрэгжүүлэх техник, программ хангамж, мэдээллийн сан, сүлжээ, хандалтын эрхийн зохицуулалт бүхий цогц орчныг;”

3 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.10 дахь заалтад заасан “, нээлттэй өгөгдөл” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, 32 дугаар зүйлийн 32.1.16 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Өгөгдлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Арван тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

1/15.37 дугаар зүйл.Өгөгдлийн тухай хууль зөрчих

“1.Хуульд заасан үндэслэлгүйгээр боловсруулсан, ашигласан өгөгдлийг бусад эх сурвалжтай нэгтгэж хүн, хуулийн этгээдийг дахин тодорхойлсон, эсхүл нууцад хамаарах мэдээллийг сэргээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Өгөгдлийн тухай хуулийн 11.13-т заасны дагуу нээлттэй өгөгдөл болгон нийтлэхийг хориглосон өгөгдлийг нийтэлсэн бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Дата төвийн үйлчилгээ үзүүлэгч хадгалж байгаа өгөгдөлд хуульд заасан үндэслэл, эсхүл эрх олгосон гэрээ, лицензийн нөхцөлгүйгээр хандсан, хуулбарласан, өөрчилсөн, устгасан, гуравдагч этгээдэд дамжуулсан, эсхүл гэрээ, лицензийн нөхцөлд зааснаас өөр зорилгоор ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Өгөгдлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... сарын ... өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.50 дахь хэсэгт заасан “15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэсний дараа “15.37 дахь зүйл” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Өгөгдлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг